

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-42

1. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 5-12

2. Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөх /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/ 12-42

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 43 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Х.Ганхуяг, М.Мандхай,
Чөлөөтэй: Х.Баттулга, П.Батчимэг, Э.Батшугар, Ж.Ганбаатар,
Б.Мөнхсоёл, Б.Найдалаа, О.Цогтгэрэл.

Нэг.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, мөн газрын дэд дарга Д.Цолмон, Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг

эрхлэх газрын дарга Н.Учрал, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөх /Засгийн газар 2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан, А.Мандуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Алимаа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ц.Өнөрнасан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, мөн яамны Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчдийн газрын дарга С.Төгсжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Шинжлэх ухааны академийн Хими, хими технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Геологи, үйлдвэрийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян, Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга Б.Гэрлээ, Хамтын ажиллагааны хэлтсийн менежер Т.Төрбадрах, Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, ашиглалтын газрын дарга С.Ган-Очир, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Усны газрын дарга З.Батбаяр, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга Г.Манлайжав, мөн Ажлын албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал, Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Мон-Атом” ХХК-ийн захирал Д.Далайжаргал, мөн компанийн Захиргааны албаны дарга Д.Сугарсүрэн, ахлах геологич А.Алтанхундага, мэргэжлийн шинжээч, Монголын Мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, профессор Я.Ганболд, Физикийн ухааны доктор Н.Тэгшбаяр, Дотоодын хуулийн зөвлөх, Г.Мөнхболд, Б.Батмандах, З.Шагдарсүрэн, С.Батхүлэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Н.Батсүмбэрэл, С.Ганбаатар, Д.Энхтүвшин, Б.Жаргалан, М.Бадамсүрэн, П.Сайнзориг, С.Энхцэцэг нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Усны газрын дарга З.Батбаяр, “Мон-Атом” ХХК-ийн захирал Д.Далайжаргал, Физикийн ухааны доктор Н.Тэгшбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Л.Соронзонболд, М.Энхцэцэг, М.Бадамсүрэн, Р.Сэддорж нар үг хэлэв.

Р.Сэддорж: Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшинг дэмжсэнээр тооцож, 85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 20 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 10 цаг 43 минут

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулна. Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сэддорж, Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Жаргалан, Лодойсамбуу, Лувсанжамц, Соронзонболд, Ундраа, Цэнгүүн, Энхтүвшин, Энхцэцэг нарын гишүүд оролцож байна. Алдаржавхлан гишүүн эмнэлгийн чөлөөтэй, Баттулга гишүүн чөлөөтэй, Батчимэг гишүүн чөлөөтэй, Бямбасүрэн гишүүн орон нутагт томилолттой, Ганхуяг гишүүн эмнэлгийн чөлөөтэй, Мандхай гишүүн эмнэлгийн чөлөөтэй, Мөнхсоёл гишүүн эмнэлгийн чөлөөтэй, Цогтгэрэл гишүүн чөлөөтэй.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

2.Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөх.

3.Монгол Улс, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хооронд байгуулах Эрчим хүч-3 төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх гэсэн ийм 3 асуудал байна.

Энэ 3 дугаар асуудал танилцуулга нь бэлэн биш байгаа учраас 3 дугаар асуудлыг хасъя. Ийм 2 асуудлаар өнөөдөр хуралдана.

3 дугаар асуудлыг хасаж байгаа юм. Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье ээ.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна аа. Гишүүний микрофоныг нээе.

Б.Пүрэвдорж: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Пүрэвдорж гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Болдын Жавхлан Сангийн сайд, Доржсүрэнгийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Доржсүрэнхорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал, Балжиннямын Гэрэлээ Эрдэнэс Монгол компанийн Хууль эрх зүйн зөвлөлийн дарга.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Батсүмбэрэл гишүүнээр тасалъя. Бадамсүрэн гишүүн асуултаа асууя.

М.Бадамсүрэн: Стратегийн ач холбогдол бүхий орд гээд хуулиудад заасан байгаа. Тэгэхээр сүүлийн үед бол стратегийн ашигт малтмалыг нэр төрлөөр нь ингэж жагсаалтыг баталж тэгээд зарладаг. Энэ тэргүүлэх гэж хэлж болох энэ нь үнэ цэнтэй энэ ашигт малтмалынхаа тухайн төрөл дээр яаж хөрөнгө оруулалт татах вэ, энэ салбарыг яаж хөгжүүлэх вэ, энэ дээр яаж илүү хөрөнгө оруулалт хийх вэ гэдгээ тооцдог ийм зүйл рүү л дэлхий нийтийн хандлага явж байна л даа. Тухайлбал ер нь бол дэлхий нийтээрээ шатах ашигт малтмалаас аль болох татгалзаж илүү энэ нөгөө металл ашигт малтмал илүү үнэ цэнтэй болж байгаа ийм зүйл рүү л бид нар явж байгаа. Тэгэхээр энэтэй холбогдуулаад энэ стратегийн орд гэдэг энэ тухайн тухайн ордоосоо буюу тэр лиценз эзэмшигчдэд чиглэсэн энэ хэлбэрээрээ цаашдаа ингэж стратегийн гэдгээ тооцож явах уу эсвэл ийм стратегийн гэж хэлж болох ашигт

малтмалын жагсаалтыг нэрээр нь баталчих энэ нь алт нь стратегийнх байх юм уу, зэс нь байх юм уу? Цайр нь байх юм уу? Газрын тос нь байх юм уу? Газрын ховор элемент байх юм уу гэдгээ тооцож явах уу? Энэ дээр ер нь Засгийн газар болоод уул уурхайн яам ер нь ямар бодлого цаашид баримтлах гэж байгаа юм бэ? 1 дүгээрт.

Хоёрдугаарт миний мэдэхийн бол энэ стратегийн гэж хэлж болох газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хугацаа бол бүүр дуусчихсан байгаа. Дуусаад ер нь шинэчилж батлаагүй их олон жил боллоо. Ер нь цаашдаа энэ ашигт малтмалын салбарт илүү аль ашигт малтмал дээр ямар хэмжээний хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох юм бэ? Яаж хөрөнгө оруулалт татах юм бэ? Энэ нь дэлхий нийтэд бусад орнуудад ямар ийм мэдээлэл хүргэж явах юм бэ гэдэг дээр ер нь баримталж байгаа ийм стратеги гэж юм ер нь байна уу? Энэ ашигт малтмал гэдэг чинь бол нөхөн сэргээгдэхгүй дэлхий нийтэд улам л үнэ цэнтэй болж байгаа. Ялангуяа энэ батарей үйлдвэрлэл, өндөр технологи, сансрын технологи, сэргээгдэх эрчим хүч гээд энэ зүйлүүд дээр чинь дандаа л үнэ цэнтэй энэ газрын ховор элемент бусад энэ металл ашигт малтмалуудын хэрэгцээ бол үлэмж хэмжээгээр цаашдаа нэмэгдэнэ. Юун газрын тос, нүүрс, шатах ашигт малтмалаас татгалзаж илүү тэгээд металл ашигт малтмал руу тэмүүлж байгаа энэ цаг үед бид нар энэ салбартаа ямар бодлого барих юм бэ? Энэ дээр ер нь Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ийм төлөвлөгөө байгаа юу? Энэ нэг жоохон тийм төлөвлөлтгүй яваад байна даа л гэж харж байгаа. Тэгээд энэ дээр хариулт авъя. Баярлалаа.

Р.Сэддорж: 4 номер Наранцогт дарга хариулъя.

Х.Наранцогт: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр стратегийн ач холбогдолтой орд газрын хувьд бол 2007 онд энэ батлагдсан манай Ашигт малтмалын хуульд ингээд тодорхой заагаад оруулсан. Ингээд 2019 онд манай Үндсэн хуульд стратегийн орд газрын үр өгөөжийн талаар ингээд ороод ирсэн. Яах вэ стратегийн ач холбогдолтой ордын манай яг энэ хууль эрх зүйд ингээд тодорхойлоод Их Хуралд энэ Ашигт малтмалын хуулийн дараа яг энэ стратегийн ач холбогдолтой ордуудын жагсаалтыг ашигтай стратегийн орд газар орох боломжтой ордын гэсэн ийм 2 хавсралт батлагдсан байдаг. Тэгээд энийг бол Засгийн газар, Уул уурхайн яам энэ хил хязгаарыг тогтоох ийм ажлууд хийх үүрэгтэй. Тэгэхээр одоо Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулга орж ирж байх энэ үед бол яг таны ярьж байгаа шиг стратегийн ач холбогдолтой ордоо яг ингэж жагсаалтаар батлах юм уу эсвэл нэр төрлөөр нь батлах юм уу гэдэг асуудлыг бол нэлээн нарийн Их Хурал дээр ярилцах байх гэж ингэж бодож байна. Уран бол Цөмийн энергийн хуулиараа шууд ингээд стратегийн орд гээд ингээд тодорхойлогдчихсон байдаг.

Чухал ашигт малтмалын тухай ойлголтыг та ярилаа. Чухал ашигт малтмал гэдгийг энэ дэлхийн орнууд сүүлийн үед их зарлаж байна. Ялангуяа таны ярьж байгаа энэ газрын ховор элементүүд зэс гээд манай улсын хувьд яг Засгийн газраас чухал ашигт малтмалаа зарлаагүй. Уул уурхайн яам нэмж хариулах байх ажиллаж байгаа. Эрдэнэс Монгол нэгдлийн хувьд яг нэгдлийн чухал ашигт малтмалыг зарлаад ирээдүйн хувьд бол бид нар яг таны хэлж байгаачлан одоогийн бид нарын уламжлалт ашигт малтмалаас илүү их потенциалный ашигт малтмалууд байна гээд энийгээ бол зарлаад энэн дээр хөрөнгө оруулалт хайгуул хийх энэ бодлогоо бол

нэгдлийн хүрээнд тодорхойлчихсон. Тэгээд хөрөнгө оруулалтын хувьд бол ер нь ялангуяа геологи хайгуул дээр бол эрсдэлтэй учраас гаднын хөрөнгө оруулалтыг татах ажлыг нэлээн хийж байгаа. Энэ дэлхийн уул уурхайн гол болдог хурлууд дээр бид нар энэ талаараа танилцуулга юм хийж байгаа.

Тодорхой потенциалын талбайнуудыг ялгаад энэ дээр бас хайгуулын лиценз авах ажлууд хийгдэж байна. Судалгаа шинжилгээний ажлууд ингээд хийгдээд явж байгаа юм аа. Тэгээд Уул уурхайн яам нэмж хариулах уу?

Р.Сэддорж: 6 номер нэмж хариулъя.

Г.Намчинсүрэн: Аж үйлдвэрийн эрдэс, баялгийн яам Намчинсүрэн. Наранцогт захирал үндсэндээ хариулчихлаа. Энэ стратегийн ач холбогдол бүхий ордын асуудлыг бол Монгол Улсын Үндсэн хуульд заагаад өгчихсөн. Тэгэхээр бид нар бол одоогийн байгаа Үндсэн хуульдаа нийцүүлээд Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа ч гэсэн стратегийн ач холбогдол бүхий орд гэсэн ойлголтыг бол орхигдуулж болохгүй байгаа. Нөгөөтээгүүр бас дэлхийн улс орнууд өндөр технологийн түүхий эд болон чухал ашигт малтмал гэдэг нөгөө талаараа нэрлээд байгаа энэ чиглэл рүүгээ ногоон эрчим хүчний шилжилт рүү шилжиж байгаатай холбоотойгоор бүгд тийшээ чиглэсэн одоо судалгаанууд руу бол эрчимжээд яваад орчихлоо л доо. Тэгээд бид нарын зүгээс ч гэсэн энэ чиглэлдээ холбогдох судалгаануудыг хийж байна. Яг ямар бүтээгдэхүүнийг болон ямар ашигт малтмалыг өндөр өндөр технологийн түүхий эд буюу чухал ашигт малтмалд хамруулах юм бэ? Нэгдүгээрт бол нөгөө газрын ховор элемент болон тэгээд одоо ашиглалтад шилжиж байгаа уран болон зэс гэх мэт бүтээгдэхүүнүүдийг бол хамруулах нь зүй ёсны хэрэг байх.

Дээр нэмэх нь жоншийгоо байлгах уу үгүй юү гэдэг иймэрхүү төрлийн судалгаануудаа хийж байгаа. Тэгээд энэ төрөл рүүгээ чиглэсэн бас улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа геологийн сэдэвчилсэн судалгааны ажлуудыг энэ чиглэлд хөрөнгийг нь зарцуулах бодлогыг баримтлан ажиллаж байна. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль гэж Улсын Их Хурлаас баталж өгсөн. Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль гээд. Энэ хуульд зааснаар бол салангид ийм эрх зүйн бодлогын баримт бичгүүдийг байхгүй болгоод үндсэндээ богино хугацааны хөгжлийн бодлогуудын баримт бичгүүдийг батлахаар хуульчлаад өгчихсөн. Энэ дотроо бол дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг дээр бол эдийн засгийн болон дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрүүд байхаар зааж өгсөн. Тэгээд бид нарын хувьд бол энэ зорилтот хөтөлбөрийн нэг хэсэг дээр бол энэ геологи, уул уурхай, боловсруулах үйлдвэрийн чиглэлийн энэ хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахаар бол төлөвлөж байгаа.

Р.Сэддорж: Тодруулж асууя. Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Яах вэ миний хувьд энэ мэргэжлийн хүнийхээ хувьд жоохон сэтгэл зовниод байгаа юм л даа. Энэ ашигт малтмалын салбарыг манай экспортын гол орлого олж байгаа эдийн засгийн хамгийн их нөлөө үзүүлж байгаа салбарын хувьд ийм тодорхой цаашдаа бодлоготойгоор яваач л гэдэг саналыг хэлээд байгаа юм. Тэгээд өөрөөр хэлбэл энэ дэлхий нийтийн чиг хандлагатай бид нар хөл нийлүүлэх хэрэгтэй. Яагаад гэвэл энэ салбар чинь нүүрсний салбарт гэхэд цахилгаан станцын салбарт хөрөнгө оруулалт бол гарахаа больсон шүү дээ. Дэлхий нийт чинь дулаарлыг 2 хэмээс хэтрүүлэхгүй бүүр 1.5-аас доош барина гэдэг ийм

зорилт дэвшүүлж конвенц гаргаад, тэгээд энэний дагуу, энэ шатах ашигт малтмалаас аль болох багасаад тухайлбал одоо газрын тос, нүүрс, тэгээд энд хөрөнгө оруулдаг эндээс илүү орлого олдог энэ Арабын орнууд хүртэл өөр төрлийн ашигт малтмалыг стратегийн зорилгоор энийг тэргүүн.

Р.Сэддорж: Хариулт 6 номер.

Г.Намчинсүрэн: Бадамсүрэн гишүүнтэй санал нэг байгаа юм аа. Тэгээд би түрүүн бас танд хэлсэн. Ерөнхийдөө бол манайх бол эдийн засгийн болон дунд хугацааны бодлогын зорилтот хөтөлбөрөө боловсруулна. Энэ хүрээндээ бол энэ энэ чухал ашигт малтмалын ерөнхийдөө бодлогоо тодорхойлж орж ирнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Чухал ашигт малтмал дээр ямар ямар арга хэмжээ авах юм бэ? Энэ чиглэл рүүгээ чиглэсэн сэдэвчилсэн судалгааны ажлуудыг яаж гүйцэтгэх юм бэ? Хамгийн гол асуудал нь манайх ер нь энд хэр потенциалтай юм бэ гэдгээ л тодорхойлох хамгийн шаардлага байгаад байгаа юм. Тэгээд энэ чиглэлдээ улсын төсвийн хөрөнгөөс тавигдаж байгаа төсвийн хөрөнгийн үнэлгээний ажил сэдэвчилсэн судалгааны ажлуудыг энэ чиглэл рүү нь бол чиглүүлээд явж байгаа.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Би хариулт авахаа больё доо. Саналаа л хэлчихье. Тэр нь дээр юм шиг байна. Одоо ингээд жоншны салбарт гэхэд энэ цаашдаа бол их чухал үнэ цэнтэй болно. Гэтэл энэ дээр ямар ч зохион байгуулалт төлөвлөлт байхгүй байгаа байхгүй юу. Жонш боловсруулах үйлдвэр байгуулах юм уу, үгүй юм уу? Хайгуул нь хаанаа илүү боломжтой юм? Хаана илүү нөөц нь байгаа юм? Энэ зүйл дээр чинь одоо яг ингээд гаргаад ирээд хэлье гэхээр ийм байхгүй байгаа байхгүй юу. Зөвхөн бид нар судалж байна л гэсэн зүйл яриад байгаа юм. Тэгээд энийг их тодорхой болгож өгөөч ээ? Цаг хугацаа хүлээхгүй байна бид нарыг. Энэ ашигт малтмалын салбартаа дэлхийн хэмжээнд бид нар илүү том тоглогч байх энэ боломжоо алдмааргүй байна л гэдэг зүйлийг л хэлээд байгаа юм л даа. Тэгээд энэ дээрээ анхаарахгүй бол болохгүй байгаад байгаа юм.

Хоёрт нь би газрын тосны талаар төрөөс баримтлах бодлого байгаа юм уу гэж асуусан. Энэ дээр би хариулт авах шаардлагатай гэж бодож байна. Тэгээд энэ чинь ямар ч ийм нөгөө бодлого байхгүй болохоор холын зорилго байхгүй болохоор ингээд ямар ч зохион байгуулалтгүй яваад байгаа харагдаад байгаа байхгүй юу. Тэгээд энэн дээр хариулт.

Р.Сэддорж: Хариулт 4 номер.

Х.Наранцогт: Бадамсүрэн гишүүний тэр жонштой холбогдуулаад би нэмээд хариулъя.

Тэгэхээр Эрдэнэс Монгол нэгдлийн хувьд бол энэ 6 стратегийн орд газар дээрээ суурилсан 6 үйлдвэр технологийн паркийн энэ хөгжлийн төлөвлөгөө хийгдээд бүүр ном болгоод энийг Засгийн газарт танилцуулаад дунд хугацааныхаа стратеги төлөвлөгөөнд оруулаад тэгээд үндсэн боловсруулах үйлдвэрээ Монросцветмет дээр суурилж байгуулагдаад тэгээд дараа дараагийн шатын

үйлдвэрүүдийг энэ хувийн хэвшлүүдэд боловсруулах энэ маш нарийн төлөвлөгөө гарчихсан байгаа. Энийг ер нь танд энэ Байнгын хорооны гишүүдэд ер нь үзүүлэх төлөвлөгөө байгаа юм. Энэ Засгийн газарт бол танилцуулагдаад ингээд хийгдээд явсан. Монросцветмет бол энэ үндсэн жоншны бизнесээ алдсан. Энийг бид нар стратеги төлөвлөгөөндөө шинэчлээд энийг бид нар сэргээж хийх ёстой. Жонш бол стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүн учраас энэ дээр онцгой анхаарна.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

Н.Батсүмбэрэл: Би Учрал сайдаас асууя. Ер нь энэ чинь Үндэсний баялгийн сангийн хууль. Тэгээд Цөмийн энергийн хууль, Хөрөнгө оруулалтын хууль, Компанийн хууль, Ашигт малтмалын хууль гээд олон хуулиудыг өөрчлөлт дээр сууж байна. Нэлээн галтай хуулиуд байна. Энэ амаргүй ажлууд явж байна аа. Тэгээд энэ Монгол Улс хөгжих асуудал яригдаж байгаа энэний ард. Монгол улс хөгжих үү, урагшлах уу гэдэг асуудлын ард нэг хэсэг нөхдүүд шээс нь гоожчих гээд давхиад байх шиг байгаа юм. Нүүрэндээ маск нааж байгаад эх оронч болж жүжиглэж байна. Зарим нь эзэд тавиул компанийнхаа төлөө шээсээ гоожуулж гүйж байна. Тэгэхээр энэ ажлыг урагш нь бид нар явуулах ёстой. Эдийн засгийн байнгын хороо Их Хурал бол энэ дээр илүү бодитой эх оронч маскгүй эх оронч эзэд ноёддоо үйлчлэлгүй эх оронч байх ёстой гэж хувьдаа бодож байгаа.

Одоогийн байдлаар бол дэлхийд илэрчихсэн бид энэний дараа ярих гэж байна л даа. Нөгөө уран. Дэлхийд илэрчихсэн нийт нөөцийн 2 хувь нь л Монгол Улсад байгаа. 10 гаруй лиценз байх шиг байгаа юм. Тэгээд үүнийхээ 3 лицензийг л хөдөлгөх гээд л оролдоод байгаа шүү дээ. Бодитой байдал дээр. Тэгээд нөгөө олон түмэнд баялгийн сангаар дамжуулж хуваарилах ирээдүйдээ авч үлдэх тухай яриад байдаг. Гэтэл хэдэн нөхдүүд тээж хэвтчихээд байдаг бодит амьдрал ийм байгаад байгаа юм. Тэгээд миний асуух гэж байгаа санаа бол одоо бид нар 2 хувь уран дээр. Бусад баялгууд дээр тодорхой нөөцүүд дээр л илэрсэн нөөцүүд дээр яриад байна. Гэтэл ирээдүйд илүү их нөөц илэрч болзошгүй байгаа. Тэгээд энэ эрэл хайгуулын ажлыг, геологийн ажлыг хэр хийж байна вэ? Энэ геологийн ажил дээр хэр төлөвлөгөө тавьж байна вэ? Энэ орж байгаа хөрөнгө мөнгөнөөс энэ геологи хайгуулын зардал дээр хэр их тавих вэ. Ер нь энэ баялгаа нэмэгдүүлэх бодлогыг хэр анхаарч байна вэ гэдэг асуулт асууя.

Р.Сэддорж: Хариулт Учрал сайд. 3 номер.

Н.Учрал: Үндэсний баялгийн сангийн хуулийг дагалдуулсан Ашигт малтмалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа бол түүхэн үйл хэрэг л гэж би бодож байгаа. Яагаад гэхээр энэ тусгай АМНАТ-ын дээд босгыг 5 хувь гээд тавьчихсан хуультай юм байна лээ. Энэ тусгай АМНАТ-ын дээд босгыг 5 хувь гээд тавьснаас болоод Монгол Улсын Ерөнхийлөгч Франц улсад айлчлах үеэр Францын тэр Орано компанитай нөгөө хэлэлцээрийн протоколд гарын үсэг зурах үйл ажиллагаа явагдсан. Энэ үед тусгай АМНАТ-ын дээд босго нь 5 хувь гээд биччихсэн хуультай учраас төрийн эзэмшлийн 34 хувийг тусгай АМНАТ-ын дээд босго 5 хувиар орлуулах л ийм эрх зүйн орчинтой байсан. Протокол ингэж зурагдсан.

Тийм учраас өсөн нэмэгдэх АМНАТ гэдэг ойлголтыг оруулж ирээд тэр нолиос 9 гэдэг энэ өсөн нэмэгдэх АМНАТ-ийг тооцож байж Үндсэн хуулийн тэр 6.2-ын дагуу 51 хувийг төр эзэмших энэ санхүүгийн схем дээрээ суурилж өнөөдрийн хөрөнгө оруулалтын гэрээ танилцуулж байгаа юм. Өнөөдрийн бидний хэлэлцэж батлах гэж

байгаа энэ Үндэсний баялгийн сангийн хуулийг дагасан Ашигт малтмалын хуулийн тусгай АМНАТ-ын дээд босго 5 хувийг хэрвээ энэ хууль батлагдаад авч хаявал цаашдаа бид нар энэ стратегийн ордууд түүний үүсмэл ордуудыг эзэмшиж байгаа компани ААН-үүдтэй төрийн эзэмшлийн 34 хувийг тогтоохдоо тусгай АМНАТ-ийг хэдээр ч тохирч болно. Тусгай АМНАТ гэдэг нь мэдээж нөгөө борлуулалтаас авч байгаа АМНАТ ингээд аваад эхлэх юм бол компанийн ашигтай ашиггүйгээс үл хамаараад бид нар борлуулалтаас нь тэр АМНАТ-ийг авснаараа өнөөдрийн энэ Үндэсний баялгийн сангийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу тэр тусгай АМНАТ-аар орлуулж байгаа хэсэг нь төсөв рүү ч биш энэ иргэний хуримтлалын сан руу шилжинэ гэсэн үг.

Тэгэхээр нөгөө иргэдийн өдөр тутам гар утаснаасаа шалгаад байгаа хуримтлалын санд хуримтлалыг надад хэдэн төгрөгийг аль төсөл урагшилснаар олж ирэв, надад хэдэн төгрөг ирэв гэдгийг хардаг. Ийм нээлттэй олборлох салбар нь өөрөө ил тод нээлттэй болж эхэлнэ гэсэн үг. Тэгэхээр энэ Үндэсний баялгийн сангийн хууль батлагдсанаар энэ бол зөвхөн энэ ураны гэрээтэй холбоотой биш энэ бол бүх салбарт үйлчилнэ. Бид бол тусгай АМНАТ-ын босгыг авлаа. Дээрээс нь төрийн эзэмшлийн 34 хувийг орлуулахдаа Их Хурал өөрөө шийдэж байгаа. Хэдэн хувийн АМНАТ дээд тал нь байх юм. Яаж орлуулах юм бэ гэдгийг Их Хурал шийдэж байгаа учраас Их Хурлаар шийдвэрлээд явах бололцоотой. Сая бас таны хэлсэн энэ 3 тусгай зөвшөөрлийн хүрээнд л бид нар хөрөнгө оруулалтын гэрээг хийж байна. үүнтэй холбогдуулаад зөвхөн энэ нэг Дорноговь аймгийн Улаанбадрах сум дээр энэ Зөөвч овоо тэр Дулаан уулын асуудал биш. Үүнээс гадна ураны нөөц тогтоогдсон олон газрууд бий. Тэгээд цаашдаа энэ төслүүд бол давхар урагшлах нөхцөл бололцоо бол бүрдэж байгаа учраас цаашдаа энд анхаарч ажиллах ёстой байх гэж бодож байна.

Р.Сэддорж: Тодруулж асууя Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Нөгөө гол асуултдаа хариулт авсангүй л дээ. Нөгөө хайгуул ер нь хэр хийх гээд байгаа юм? Одоо энэ чинь 2 хувь нөөц илэрчхээд байдаг. Цаашаа энэ Монгол орноос газар нутгаас уран олдох юм уу? Болзошгүй Тийм олдож нөгөө хүмүүсийн татаж унах гээд байгаа шиг Оюу Толгой нэмж олдох юм уу яах юм? Энийг л асуугаад байна. Тэгээд энэ дээр хөрөнгө мөнгө тавьж байна уу? Яаж байна?

Р.Сэддорж: Хариулт 4 номер Наранцогт дарга.

Х.Наранцогт: Би түрүүн Бадамсүрэн гишүүний асуултад хариулахдаа товчхон хэлсэн. Ер нь манай улсын энэ уулын геологийн нөхцөлийн энэ урьдчилсан судалгааг харах юм бол бид нарт ялангуяа уран дээр газрын тодорхой ховор элементүүд дээр ийм боломжууд байгаад байгаа юм. Тэгэхээр бид энэ судалгааг эрдэмтдийн өмнөх судалгаа, өөрсдийн бас энэ төслийн багуудын судалгааг нэгтгээд нэлээн хэдэн талбайнуудыг ялгаад энэний хайгуулын лиценз авах энэ процедур явж байгаа юм.

Уран дээр бол ялангуяа манайх бололцоо нэлээн байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ зүйл хийгдэж байгаа. Геологийн ажлаа 4 хувааж байгаа. Ер нь эрсдэл багатай өөрөөр хэлбэл урьдчилсан нөөц тогтоогдсон энэнийхээ нарийвчилсан нөөцийг ингээд тогтоох ажлыг бид өөрсдийн хөрөнгөөр хийнэ гээд ингээд тухайлбал Асгат дээр бид нар.

Р.Сэддорж: 4 номер гүйцээж хариулья.

Х.Наранцогт: 10 гаруй тэрбум төгрөг тавиад энэ нөгөө стандарт олон улсын стандартаар яг нөөцөө бүрэн тогтоох ийм ажил хийж байна. Тэгэхээр 4 хуваана гэдэг маань ингээд өөрөө энэ хайгуулын ажил их эрсдэлтэй. Шинээр зүгээр ер нь потенциалный байгаа хайгуулын ажил дээр аль болох гаднын хөрөнгө оруулагчтай эрсдэл хуваах маягаар хайгуулын ажилд хөрөнгө оруулах ийм бодлого барьж ажиллаж байна зүгээр. Ер нь урьдчилаад нөөц тогтоогдчихсон. Яг олон улсын стандартаар бид нар нөөцөө тогтоочих юм бол эдийн засгийн хөрөнгө эргэлтэд оруулах хөрөнгө оруулагчид олдох юм байна лээ. Тэгэхээр энэ хэсэгтээ өөрсдөө мөнгөө гаргаад ийм хайгуулынхаа яг нарийвчилсан нөөцийг олон улсын стандартаар тогтоох ажлууд хийгдээд төлөвлөгөө гараад ингээд ажиллаж байгаа юм.

Яах вэ эрсдэл өндөртэй дээр ингээд бид нар эрсдэл өндөр байгаа учраас аль болох гаднын хөрөнгө оруулалт.

Р.Сэддорж: Асуулт. Бүх татваруудаа ингээд баялгийн сан руугаа хийж байгаа түүхэн цаг үе өөрчлөлт орж байна. Хуульд өөрчлөлт орж байна. Ингээд энэ хэр тогтвортой арвижих вэ? Сонгууль дөхөхөөр тараачих эрсдэл байх уу? Засаг солигдохоор янз бүрийн эрсдэлд орох уу? Энэ тогтвортой арвижих баталгааны талаар асууж байна. 4 номер.

Х.Наранцогт: Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн хуулийг батлах процесст бид нар Их Хурал дээр ирээд 2 зүйлийг ер нь хийсэн үе шаттай явъя. Эхний ээлжид ямар ч байсан 2030 он хүртэл энэ Баялгийн сангийн, ялангуяа хуримтлалын сангийн, Ирээдүйн өв сангийнхаа хөрөнгийг бол найдвартай зарцуулахгүйгээр ингээд түгжье ээ. Хөрөнгийн менежмент хийх хэмжээний хөрөнгө 1 дүгээрт хуримтлагдах ёстой.

Хоёрдугаарт аль болох эрсдэлгүй байлгах ёстой. Бидэнд өмнө нь ингээд энэ сангуудаа үрж тарсан буруу замаар уруулсан ийм гашуун туршлага байгаа учраас энэ хөрөнгийн удирдлагын боловсон хүчин компани эрх зүйгээ бэлдэх энэ хугацааг 2030 он гэж үзээд ингээд ийм байдлаар явж байгаа. Тэгэхээр зарцуулагдах боломжгүй. Монголбанк хөрөнгө оруулалтад найдвартай эрсдэлгүй хөрөнгө оруулалтад хийх мандатыг бол Засгийн газартай гэрээ байгуулах журмаар авч байгаа. Тэгэхээр хөрөнгийн нэмэгдэх асуудал бол тогтвортой нэмэгдэх бололцоо байна.

2030 он хүртэл зарцуулах бололцоогүй байгаа. Тэгэхээр хөрөнгийн удирдлагын компанийг бэхжүүлэх хөрөнгийн удирдлагын чиглэлийн эрх зүйг боловсронгуй болгох үүргийг Үндэсний баялгийн сангийн хуулийг дагалдаж гарсан тогтоолоор Засгийн газарт үүрэг өгсөн. Өнгөрсөн Засгийн газрын хуралдаанаар бид нар энэ хөрөнгийн удирдлагын менежментийн бэлтгэлийг хийх компани байгуулагдах шийдвэр гарсан. Энэ компани бол эдгээр ажлын бэлтгэл ажлуудыг хийхээр ингэж төлөвлөж ажиллаж байгаа юм аа. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол ямар ч байсан 30 он хүртэл энэ хөрөнгө бол тогтвортой арвижна. Элдэв буруу зам төсвийн нөхөөс болох ийм эрсдэл бол байхгүй гэдэг зүйлийг хэлье.

Р.Сэддорж: Хариулт нэмж хариулах хүн байхгүй байна уу. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж уншиж танилцуулна аа.

11.13 цагт

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 2.

Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг явуулъя аа.

Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал танилцуулна аа. Сайдын микрофоныг нээе.

Н.Учрал: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Орано Майнинг Компани хооронд байгуулах уран олборлох төслийн хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Монгол Улсын эрх ашиг хууль тогтоомжид нийцүүлж хөрөнгө оруулагч талтай урьдчилан тохирч боловсруулж Цөмийн энергийн тухай хуулийн 30.3-д заасны дагуу зөвшилцөхөөр танилцуулж байна аа. Зөвч овоо Дулаан уулын ураны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах энэхүү төсөл нь Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Улсын хөгжлийн бүтээн байгуулалтын 14 мега төслийн нэг бөгөөд энэхүү гэрээг хэрэгжүүлснээр гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж улс орон нутгийн төсөвт хөрөнгө төвлөрүүлэх ажлын байрыг бий болгох, шинэ технологи, нутагшуулах мөн олон улсын хамтын ажиллагаа зэрэг нийгэм эдийн засагт үзүүлэх шууд нөлөөллөөс гадна цаашид уул уурхай ашигт малтмалын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын гэрээнд жишиг тогтоох үр дагавартай.

Хөрөнгө оруулагч нь Монгол Улсад 1997 оноос хойш хайгуул олборлолтын чиглэлээр тасралтгүй 27 жил үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 2021 оны 7 дугаар сараас Зөвч овоо ордын үйлдвэрлэлийн туршилтыг эхлүүлж 2022 оны 12 дугаар сард амжилттай гүйцэтгэж дуусгасан.

2023 оны 5 дугаар сараас эхлэн Монгол Улсын Ерөнхий сайдын хэд хэдэн захирамжаар Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн хэлэлцээ хийж эцэслэн боловсруулсан хувилбарыг Засгийн газрын хуралдаан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгүүд тус ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид, хөндлөнгийн төлөөлөл бүхий өргөн бүрэлдэхүүнтэй ажлын дэд хэсгүүд, гэрээ, эрх зүй, эдийн засаг, хөрөнгө оруулалт, татвар, санхүү, олборлолт, үйлдвэр, технологи, байгаль орчин, орон нутаг гэсэн 5 чиглэлд салбарын сайдуудаар ахалсан ажлын хэсэг байгуулагдаж гэрээний хэлэлцээг үргэлжлүүлэн хийж эцсийн хувилбарыг боловсруулан танилцуулж байна аа.

Ажлын хэсгээс гэрээний төслийн хувилбарыг боловсруулахдаа Монгол Улсын эрх ашигт нийцсэн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа дийлэнх үр өгөөж ард түмэнд ноогдож байх талуудын хүртэх өгөөжийг тэнцвэртэй хангах суурь зарчмуудыг хатуу баримталж ирээдүйд аливаа эрх зүйн үр дагаваргүй хэрэгжих боломжийг бүрдүүлэх цаашид жишиг гэрээ болох нөхцөлийг хангахад анхаарсан болно оо. Мөн энэ чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий мэргэшсэн санхүү, хууль, байгаль орчны зөвлөхүүд болон дотоодын зөвлөхүүдтэй хамтран ажилласныг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын хууль тогтоомж олон улсын эрх зүйн зарчмыг баримтлан хөрөнгө оруулагчдаа нийт 18 удаагийн хэлэлцээг хийж Монгол Улсын эрх ашиг Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимд нийцүүлэн боловсрууллаа. Эдийн засаг хөгжлийн сайдаар ахлуулсан ажлын дэд хэсэг ажиллаж, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах нөхцөлүүдийг урьдчилан тохиролцсон.

Үүнд:

Анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь ойролцоогоор 500 сая ам.доллар байх бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс хойш 4 жилийн хугацаанд хийхээр тусгаж хөрөнгө оруулагчийг хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой хугацаатай зааж өглөө. Анхны хөрөнгө оруулалтын хувьд төслийн хөрөнгө оруулалт үйл ажиллагааны санхүүжилтийг зээл түүнтэй адилтаж санхүүгийн хэрэгслээр бүрдүүлэхгүй өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тохирсон ба төслийн хугацаанд хувь нийлүүлэгчийн зээлийг зөвшөөрөхгүй зээл авах зайлшгүй шаардлага үүссэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэхээр тохирлоо. Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө төсөл хэрэгжүүлэгч компанид олгосон хувьцаа эзэмшигчийн зээлийг төсөл хэрэгжүүлэгч компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд шилжүүлэхээр тохирлоо. Хөрөнгө оруулагч талаас ирүүлсэн санхүүгийн тооцооллын шууд ашиглахаас илүүтэй ТЭЗҮ-д тулгуурлан олон улсын фастандартын дагуу өөрийн талын санхүүгийн тооцооллын загварыг Монголын талаас боловсруулж хөрөнгө оруулагчдаа тулган баталгаажуулалт хийсний үндсэн дээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үр өгөөжийн дийлэнх хэсэг буюу 51-ээс доошгүй хувийг Монгол Улс хуримтлагдсан дүнгээр жил бүр хүртэх нөхцөлийг баталгаажуулж өглөө.

Гэрээний төсөлд Засгийн газар болон хөрөнгө оруулагч талд ноогдох шууд үр өгөөжид тооцох орлогыг тусгайлан дурдаж хэрэв Монголын талын шууд үр өгөөж 51 хувьд хүрэхгүй байгаа тохиолдолд хөрөнгө оруулагч болон төсөл хэрэгжүүлэгч компани нь үр өгөөжийг 51 хувьд хүргэх хэд шаардлагатай үр өгөөж тохируулах нэмэлт төлбөрийг Засгийн газарт нөхөн төлөх үүрэгтэй байхаар тохиролцлоо. Засгийн газар төсөл хэрэгжүүлэгч компанийн эздийн өмчийн 10 хувьтай тэнцэх төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцааг үнэ төлбөргүй шууд эзэмших ба хувь хэмжээг бууруулахгүй байхаар тохирлоо.

Засгийн газар нь бүтээгдэхүүний 10 хүртэлх хувийг хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл болзлын дагуу худалдан авахаар гэрээний төсөлд тусгалаа.

Засгийн газар нь компанийн дүрэмд өөрчлөлт орох, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, баталгаа гаргах болон хөрөнгө оруулалтын болон үйл

ажиллагааны зардалд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар хориг тавих эрхтэй байх заалтыг тусгаж өглөө. Мөн татвар санхүүгийн чиглэлээр хөрөнгө оруулагч талаас нийт 27 төрлийн татварыг тогтворжуулах саналыг ирүүлснийг хэлэлцээрийн явцад бууруулж зөвхөн ААНОАТ, НӨАТ, АМНАТ, гаалийн тариф гэсэн 4 төрлийн татварыг тогтворжуулахаар тохирлоо.

Татвар тооцох аргачлалыг өргөн утгаар нь тогтворжуулах саналыг ирүүлснийг хэлэлцэж, зөвхөн татварын төрөл, хувь хэмжээ, элэгдэл хорогдолд тооцох хугацаа, алдагдал, ирээдүйд шилжүүлэн тооцох хугацаа гэсэн 3 үзүүлэлтийг л тогтворжуулахаар тохирлоо.

АМНАТ-ийг үндсэн болон нэмэгдүүлсэн хувиар тооцох бөгөөд тусгай төлбөрийг бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс хасагдуулах инфляц тооцохгүйгээр бүрэн төлөхөөр тусгалаа.

Татварын суурийг багасгах ашиг шилжүүлэхийн бепс эсрэг зарчим болон дотоодын хуулийг бүрэн дагаж мөрдөхөөр гэрээний төсөлд тусгалаа. Маркетингийн төлбөрийг татварын болон санхүүгийн тайлангийн зорилгоор хасагдах зардалд зардлаар бүртгэхгүй болохыг хэлэлцээрийн явцад хөрөнгө оруулагч талдаа тохирч зөвшөөрүүлээ. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 286 дугаар тогтоолоос хойш өнөөг хүртэл шар нунтгийг ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүнд тооцож экспортод тэг хувийн НӨАТ ноогдуулан буцаан олгохоор заасныг өөрчлөхөөр хатуу байр суурийг баримтлан хэлэлцээрийг хийлээ.

Хөрөнгө оруулагч талаас зөвхөн ураны төсөлд зориулж тогт өөрчлөхийг зөвшөөрөх боломжгүй гэсэн байр суурийг илэрхийлж байлаа. Улмаар хэлэлцээрийн явцад Засгийн газар эцсийн бүтээгдэхүүнд тэг хувийн НӨАТ ноогдуулах асуудлаар нэгдсэн бодлогоор бүх уул уурхайн компанид ижил хандсан тохиолдолд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөхийг зөвшөөрөх боломжтой талаар хөрөнгө оруулагч талтай харилцан ойлголцолд хүрч гэрээний төсөлд тусгалаа.

Энэхүү хөрөнгө оруулалтын гэрээг байгуулж хэрэгжүүлснээр улс орон нутгийн төсөвт жилд 520 тэрбум, төслийн нийт хугацаанд 17.1 их наяд төгрөг, Үндэсний баялгийн санд жилд 61.5 тэрбум төгрөг төслийн нийт хугацаанд 2 их наяд төгрөгийг төвлөрүүлж 1600 орчим ажлын байрыг шинээр бий болгож, шинэ технологи нутагшуулж, хүхрийн хүчлийн үйлдвэр зэрэг бүтээн байгуулалт хийгдэх боломж бүрдэх болно.

Энэхүү ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсанаар гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж шинэ төрлийн үйлдвэрийг хөгжүүлэх төсвийн орлого ДНБ-ий өсөлт, ажлын байрыг нэмэгдүүлж, дэвшилтэт технологи, мэдлэг туршлагыг нэвтрүүлж мэргэшсэн боловсон хүчний нөөц бүрдүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг бий болгохоос гадна Монгол Улс стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн экспортлогч орон болж улмаар ураны зах зээлийн гол тоглогчдын нэг болох нүүрсхүчлийн хий ялгаруулдаггүй цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэх эхлэл тавигдах болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Орано Майнинг компанийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хэлэлцэн дэмжиж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Учрал сайдад баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ням-Оосорын Учрал Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга, Болдын Жавхлан Сангийн сайд, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засгийн хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга, Баатарын Мөнхтогтох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны салбарын хяналтын газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Зинээмядарийн Батбаяр Усны газрын дарга, Цэрэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга, Бямбаагийн Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газар Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга, Гунаажавын Манлайжав Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Мавагийн Чадраабал Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга, Сэр-Одын Ган-Очир Ашигт малтмалын газрын Газрын геологи ашиглалтын газрын дарга, Лхасүрэнгийн Жаргалсайхан Шинжлэх ухааны академи Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал, Бат-Эрдэнийн Хулан ЗГХЭГ-ын даргын зөвлөх, Алтангэрэлийн Мандуул ЗГХЭГ-ын даргын зөвлөх, Цагааны Өнөрнасан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи уул уурхайн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч, Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал, Лувсаншаравын Наранчимэг Эрдэнэс Монгол компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Балжиннямын Гэрлээ Эрдэнэс Монгол компанийн нэгдлийн Хууль эрх зүйн зөвлөлийн дарга, Цэдэнбалжирын Төгсбуян Эрдэс Монгол компанийн Геологи үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга, Түмэнжаргалын Төрбадрах Эрдэнэс Монгол компанийн хамтын ажиллагааны хэлтсийн менежер, Доржбалын Далайжаргал Мон-Атом компанийн захирал, Амарсайханы Алтанхундага Мон-Атом компанийн уул уурхайн ахлах инженер, Дашдаваагийн Сугарсүрэн Мон-Атом компанийн захиргаа удирдлагын албаны дарга, Лхагвын Өнөрбаатар Эрдэнэс Оюу Толгой компанийн Геологи уул уурхайн хэлтсийн ерөнхий менежер, Батцэнгэлийн Баяр-Өлзий Эрдэнэс Оюу Толгой компанийн санхүү шинжилгээний хэлтсийн ерөнхий менежер, Цэрэндоржийн Мөнх-Оюунбаатар Эрдэнэс Оюу Толгой Компанийн хуулийн хэлтсийн мэргэжилтэн, Дашдоржийн Баярхүү олон улсын харилцааны судлаач профессор, Яндагийн Ганболд Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич профессор, Норовын Тэгшбаяр Физикийн ухааны доктор, Ганбатын Мөнхболд Дотоод хуулийн зөвлөх, Баярбатын Батмандах Дотоодын хуулийн зөвлөх, Зуунайн Шагдарсүрэн Дотоодын хуулийн зөвлөх, Сүхдоржийн Батхүлэг Дотоодын хуулийн зөвлөх.

Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе.

Энэ гэрээний бүтээгдэхүүний борлуулалтын үнийг тооцохдоо 2 биржийн дунджийг ашиглаж байгаа. Гэтэл нэг бирж нь болохоор Росатом компанийн эзэмшлийн бирж байна. Нөгөөдөх нь болохоор бол дэлхийн эдийн засгийн форум эзэмшдэг ийм бирж байна аа. Хэрвээ энэ бирж 2 биржийн үнэ хэтэрхий хоорондоо зөрүүтэй байх юм бол дундаж үнэ зах зээлийн дунджаас бага гарч ирнэ ээ. Тэгэхээр энэ тал дээр манайхан ер нь юу гэж бодсон бэ гэдэг асуулт байгаад байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт болохоор энэ 2 бирж маань өөрөө дэлхийн зах зээлийн борлуулалтын хэд хэдэн хувийг эзэлдэг вэ? Үнийн зөрөө хэр их байдаг вэ гэдэг ийм асуулт байна аа.

Р.Сэддорж: Хариулт нэг номер өөрийгөө танилцуулаад.

Б.Тэлмүүн: Сангийн яам Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Бүтээгдэхүүний борлуулалтын үнэтэй холбоотой 2 асуудал байгаа. Бид 1 дүгээрт борлуулалтын үнийг хэт багаар юм уу, хэт өндрөөр толгой компанитай гэрээ хийхээс сэргийлж энэ хөрөнгө оруулалтын гэрээн дээр тодорхой дүрмийг тусгасан. Тэгэхээр энэ дээр бол зах зээлийн үнэтэйгээ уясан ийм томъёоллын бүтээгдэхүүний борлуулалтын үнүүдийг нэр томъёоны тодорхойлолт оруулсан байгаа. Тэгэхээр хэт багаар юм уу, үнэ шилжилт хийх ийм эрсдэлээс сэргийлсэн.

Хоёрдугаар таны асуулттай холбоотой УХС болон Трэйд Тек гэдэг энэ 2 эх сурвалжийн нэрийг оруулсан. Уран бол өөрөө зэс юм уу алт шиг дэлхий дээр ингээд өргөн арилжаалагддаг бүтээгдэхүүн биш. Нэлээн хязгаарлагдмал ийм нөхцөлд арилжаалагддаг. Тэгэхээр ер нь олон улсад хамгийн найдвартай байж болох 2 үнийн эх сурвалж л энэ юм байна лээ. Энэ 2 үнээр борлуулалтын үнэлгээг уяж тооцсон байгаа. Тэгэхээр аль нэгээс нь хамаарахгүй.

Гурав дахь асуудлын хувьд бол бид АМНАТ-ийн зорилгоор Засгийн газар ямар эх сурвалжийн үнээр АМНАТ-аа бодож авах вэ гэдэг эрхээ бид хадгалж үлдсэн. Тэгэхээр АМНАТ-ийн зорилгоор бид тухайн үедээ судалгаа хийж байгаад Засгийн газар УХС юм уу Трэйд Тек ч юм уу эсвэл өөр боломжит эх үүсвэр байх юм бол бид өөрөө тухай тухайн үедээ сонгоод явна. Тэгэхээр бид АМНАТ-ийн зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээнд ямар нэгэн үнийн эх сурвалжтай уяж тогтворжуулсан зүйл байхгүй. Энэ бол бид нарын хэлэлцээрийн явцад зөвшөөрүүлж чадсан нэг ийм давуу тал байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Тодруулж асууя Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Тэгэхээр Цөмийн энергийн тухай хуульд болохоор нөгөө ашигт малтмалын нөөцөө тооцохдоо борлуулалтын үнээс тооцож байгаа шүү дээ 5 хувь өсөн нэмэгдүүлж байгаа хувиа тиймээ. Тэгэхээр энэ үнэ чинь болохоор

борлуулалтын үнэ биш болохгүй юм уу? Борлуулалтын үнэ гээд энэ дээрээ заачихсан байна шүү дээ гэрээн дээрээ.

Р.Сэддорж: Нэг номер хариулъя. Нэмж хариулъя.

Б.Тэлмүүн: АМНАТ-ийг бол борлуулалтын үнэд ноогдуулдаггүй. АМНАТ-ийг бол ашигт малтмалын нөөцийн төлбөр болон цөмийн энергийн хуулиар борлуулалтын үнэлгээнд тооцдог. Энэ борлуулалтын үнэлгээ бол тухайн компанийн энэ борлуулалтын үнэ 2 өөр ойлголт. Энийг бол ер нь жишиг үнэ гээд ингээд Засгийн газраас тухай бүр зарладаг. Тэгэхээр энэ борлуулалтын үнэлгээ энэ 2 бол зөрүүтэй ч байж болно, ижил ч байж болно. Энэ 2 тусдаа ойлголт. АМНАТ-ийн зорилгоор борлуулалтын үнэлгээгээ яаж тооцох вэ гэдэг нь Засгийн газар Монгол Улсын өөрийнх нь бүрэн эрхийн асуудал. Энд ямар нэгэн тогтворжилт хамаарахгүй.

Р.Сэддорж: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүнийг нэмээрэй. Соронзонболд гишүүн болсон уу?

Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

Н.Батсүмбэрэл: Тэгээд энэ Орано Майнинг Компани болон Засгийн газрын энэ хамтын ажиллагаанд амжилт хүсье. Тэгээд энэ Монгол Улсад хэрэгтэй нэг том хөрөнгө оруулалтын ажил болж байна. Тэгээд хүмүүс чинь Оюу Толгой ярьж бүх насаараа амьдарч байна. Энэ чинь тэгээд маргаантай мэтгэлцээнтэй ч гэсэн улс оронд хувь нэмрээ оруулж байна. Энэ нэг том төсөл нэмэгдэх байх гэж бодож байна. Тэгээд холбогдох хүмүүс нь хариулна биз дээ. Энэ газрын доор уусган олборлох арга арга гэдгээ олон нийтэд их сайн тайлбарлаж өгмөөр байгаа юм. Нөгөө ил уурхайтай адилхан ухаж түнхээд л шороо зөөгөөд л энэ тэнүүгээр хог хаягдал үүсгээд л бужигнуулаад байгаа юм шиг ойлголт нийтэд байгаад байгаа юм. Нөгөө нүүрсний уурхай алтны уурхай шиг тэгээд энэнээс арай өөр аргаар хийдэг юм байна гэдэг нь Их Хурлын гишүүд ажлын хэсэг очоод үзсэн шүү дээ. Бодитой мэдээлэл дээр. Тэгээд үүнийг олон нийтэд хүргэх ажлыг их муу хийгээд байгаа. Тэр нөгөө Мон-Атом гээд компани ажил хийхгүй байгаа л гэж би үзэж байгаа. Энийг мэдээлэлжүүлэх ажил хийхгүй байгаа. Тэгээд энийг нэг олон нийтэд сайн хэлж өгөөч. Энэ газар доор уусган олборлох арга гэдэг маань нөгөө хүмүүсийн мэддэг нөгөө нүүрс, алт, зэс олборлохоос ямар өөр юм бэ гэдгийг нэгдүгээрт.

Хоёрдугаарт тэр хог хаягдал Ганбаатар гишүүн яриад л байсан тиймээ. Хог хаягдлаа хэрхэн устгах гэж байна? Тээвэрлэх гэж байна, булшлах гэж байна? Тэгээд тэр гарч байгаа хог хаягдал бид чинь байгалийн ураныг олборлоод шар нунтаг гаргах хэмжээнд очих юм шиг байгаа юм. Түүний дараах цөмийн хаягдал гарахгүй юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ байгалийн ураны хог хаягдлыг хэрхэн та нар булшлах гэж байгаа юм. Устгах гэж байгаа юм? Үүнийгээ яаж шийдэх гэж байгаа юм? Энэ байгальд ямар хор уршигтай байх юм. Энийг нэг тодорхой олон нийтэд хүргэж мэдээлмээр байна.

Дараагийн асуудал тэр орон нутгийн иргэдэд ямар дэмжлэг, туслалцаа үзүүлэх юм. Энэ чинь катко дээр тодорхой ажлын хэсэг очоод үзэцгээсэн. Тодорхой мэдээллүүд авсан. Дорноговь аймагт Улаанбадрах суманд амьдарч байгаа иргэдэд энэ төсөл хэрэгжсэнээрээ ямар давуу талууд бий болох юм? Ажлын байр яаж нэмэгдэх юм? Монгол ажилчид хэдэн хувийг нь эзлэх юм? Энийгээ гэрээнд хэрхэн тусгаж байгаа гэдэг дээр мэдээлэл өгөөч гэж хүсэж байна.

Р.Сэддорж: 6 номер. Өөрийгөө танилцуулаарай.

Н.Тэгшбаяр: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Физик ухааны доктор Норовын Тэгшбаяр байна. Тантай тэр технологийн талаар санал нэг байна. Энэ технологи бол газар доор уусган баяжуулахдаа битүү системээр уусган баяжуулдаг. Тийм учраас бол нөгөө таны хэлж байгаа шиг ил уурхайтай зүйрлэх зүйл байхгүй. Тийм учраас хүмүүсийн хэлж байгаа шиг энэ ер нь өнгөрсөн хугацаанд газар доор уусган баяжуулах аргатай холбоотойгоор цацрагийн эрсдэл авсан ийм зүйл өнөөдрийг хүртэл бүртгэгдээгүй энийг олон нийтэд танилцуулах нь зүйтэй гэдэг дээр санал нэг байна. Энэ өнгөрсөн хугацаанд Мон-Атом бол энэ чиглэлийн нэлээн ажил хийж байгаа боловч үнэндээ худал үг хондоли даваад явчхаад байгаа учраас үнэн хүрэхгүй байгаад уучлаарай.

Р.Сэддорж: Өөр нэмж хариулах хүн байна уу? 6 номер гүйцээж хариулъя.

Н.Тэгшбаяр: Тэгээд энэ цацрагийн хог хаягдлын тухайд бол энэ байгалийн энэ чинь нөгөө атомын станц ч юм уу бусад ингээд цөмийн байгууламжуудаас өөр. Яагаад гэвэл энэ байгаль дээр байгаа ураныг олборлож байгаа учраас байгаль дээр байгаа урантай холбоотой л хог хаягдал гарна. Олон нийтэд бол манай энэ хууль дээр бол аюултай хог хаягдал гээд нэг тийм үг байдаг юм байна. Энэ үгтэй андуураад байгалийн энэ цацраг идэвхт хаягдлыг ингээд андуураад байгаа юмнууд байгаа. Тийм учраас энийг ялгаж салгаж олон нийтэд ойлгуулах нь зүйтэй. Энэ бага цацраг идэвхт хаягдал гарна. Энийг бол менежмент хийх нь бол тийм хэцүү зүйл биш. Стандартын хувьд бол асуудалгүй юм байгаа юм аа.

Р.Сэддорж: Байгаль орчны яамнаас уу? Нэмж хариулъя 6 номер

Д.Далайжаргал: Мон-Атом компани Далайжаргал байна аа. Хог хаягдлын хувьд ийм учиртай шүү. ТЭЗҮ дээр 3 төрлийн хог хаягдал гарч байгаа юм аа. Аюултай хог хаягдал бага цацрагт хог хаягдал, ердийн хог хаягдал гээд. Аюултай хог хаягдал гэдэг нь тэр нэрлээд байгаа тэр бол шатах тослох материал зай хураагуур, дугуй энэ тэр гэсэн тийм зүйлүүд байгаа. Бага цацрагт хог хаягдал болохоор зэрэг шар нунтагтай харьцаж байсан сав, баглаа боодол, бээлий энэ тэр, гэсэн тийм зүйлүүд байгаа юм аа. Энийг шатаана заримыг нь булшилна гэсэн ийм байдлаар явж байгаа. Хог хаягдал дээр 400-аад мянган долларын менежмент тавьчихсан байгаа. Олон нийттэй харилцах чиглэлээр Мон-Атом компани сүүлийн үед хийж байгаа. Та бүхэн харж байгаа байх. Фэйсбүүкээр бид нар 1 сая хүнд хэрэглэгч дээр дамжуулж бид нар бага хэмжээний уран гэж кино хийсэн. Энийгээ бид нар хэсэгчлээд 2, 2 минутаар хийж байгаа.

Хоёрдугаарт бид нар өнгөрсөн онд гэхэд 3 жилийн хугацаанд гэхэд зөвхөн Улаанбаатар дээр энэ туршилтын үйлдвэрийг 1680 хүн очиж үзсэн байдаг. Зөвхөн өнгөрсөн онд гэхэд 530 хүн энэ газар доор уусгах технологийг үзсэн байгаа. Улаанбадрах сум өөрөө 1400 хүнтэй гэхэд ихэнх нь бол орон нутгаас хөдөө орон нутгаас очиж төслийг очиж үзэж байгаа. Бид нар энэ чиглэлээр идэвхтэй ахиад ажлууд хийж явж байгаа.

Р.Сэддорж: 6 номер гүйцээж хариулъя.

Д.Далайжаргал: 2016 онд орд ашиглах гэрээ байгуулсан. 2016 оны орд ашиглах гэрээгээр бол нийт ажилчдын 90-ээс дээш хувь нь Монгол ажилтан байна. Тэр дотроо бол 5-аас доошгүй хувь нь Улаанбадрах сумын иргэд байна гэсэн энийг зааж өгсөн байгаа. Яг өнөөдөр боловсон хүчний асуудлаар бол Улаанбадрах сум Дорноговь аймгаас нийтдээ 77 хүүхдийг яг энэ технологийн сургалтад хамруулаад магистр бакалаврын түвшинд сургасан байдаг. Нийтдээ 65 багшийг 3 жилийн хугацаанд яг энэ газар доорх уусган олборлох технологиор цаашид ажиллуулахаар бэлдсэн байдаг. Монгол Улсын ШУТИС Дорноговь аймгийн Политехник коллежтой 3 талын хамтын ажиллагааны гэрээ байдаг. Гэрээгээр байнга энэ сургалтыг явуулж байгаа. Төсөл хэрэгжилт нийтдээ 8 сая долларыг боловсон хүчин зарцуулна. Одоо яг Катко буюу Казахстаны 2 геологич 6, 6 сарын хугацаагаар радиациар ажиллаж байгаа. Орано төв дээр 2 Монгол хүн ажиллаж байгаа.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн тодруулж асууя.

Н.Батсүмбэрэл: Тэр юуг нэг тодруулаад хариулчихмаар байгаа юм. Тэр мэдээлэлжүүлэх ажлыг их сайн л хиймээр байгаа юм даа. Би зүгээр өөрийнхөө хувьд чамлалттай харагдаад байгаа юм. Тэгэхгүй болохоор нөгөө олон нийт мэдээлэлгүй учраас буруу ойлголттой учраас тэрийг чинь мушгиад байна шүү дээ. Тэгээд ямар ч байсан хүмүүс 2 толгойтой хурга гардаггүй гэдгийг ойлгогчоод байгаа одоо бол. Тэгээд цаашаа илүү тэр энэ сая Тэгшбаяр докторын хэлдэг тэр технологийн талаар мэдээлэл өгмөөр байгаа юм. Далайжаргал чинь дипломатч юм байна лээ тийм ээ? Тэгээд энэ олон улсын харилцаа талаас нь энэ яаж дүгнэж байгаа юм. Энэ Монгол-Орос, Монгол-Хятад гээд харилцаа байж байна.

Гуравдагч хөршийн харилцаа байж байна. Энэ төсөл хэрэгжсэнээр ямар олон улсын нөхцөл байдал үүсэх вэ? Ямар давуу талууд байна вэ? Ямар сул талууд үүсэх вэ? Энэ дээр нэг өөрийнхөө хувьд нэг дүгнэлт хэлээч.

Р.Сэддорж: 6 номер хариулт.

Д.Далайжаргал: Энэ төслийг зөвхөн Монгол Францын төсөл гэж харж болохгүй ээ. Франц улс өөрөө та бүхэн мэдэж байгаа цөмийн эрчим хүчийг баяжуулж уран баяжуулдаг тавхан улсын нэг. 85 хувь нь өөрөө цөмийн эрчим хүчинд ажилладаг. Манай авсан шар нунтаг 2028 оноос эхлээд зөвхөн Франц төдийгүй хөрш зэргэлдээ 8 улсад тог цахилгаан болж очих юм. Англи, Герман, Испани, Швейцар, Люксембург, Бельги гэсэн орнуудад тог цахилгаан болж очно. Ялангуяа одоо яг манайхтай адилхан оргил ачааллын үед энэ хөрш орнууд маань л Францаас цөмийн эрчим хүчээ авдаг. Тийм учраас энүүгээрээ нэг давуу талтай. Манай нэр хүнд нэмэгдэнэ. Манай олон улсын харилцаанд манай аюулгүй байдал улам баталгаажуулна. Манай хамтын ажиллагаа Европын орнуудтай хамтын ажиллагаа өснө гэж үзэж байгаа.

Р.Сэддорж: Маш итгэлтэй хариулж байна даа. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Манай доктор сая энэ хууль дээр л нэг аюултай хог хаягдал гээд нэг үг байгаа учраас л аюултай гэж яриад байгаа юм шүү. Ер нь аюулгүй шүү л гэж хэлээд явчихлаа. Ингэж аймшигтай битгий долоогоорой. Тэр Француудын өмнө та нар очоод хэлэлцээрт орно шүү дээ. Энэ байгаль орчны найзууд маань ер нь таг дуугүй байх юмаа. Үндсэн хуулийн 6.2-ыг уншаарай. Ашиг орлогоос илүү энэ ашигт

малтмал ард түмний ашигт малтмалыг ухахдаа та нар нийт ард иргэдийн болон байгаль орчны аюулгүй байдлыг эн тэргүүнд эрэмбэлнэ гэж заасан байгаа шүү. Тэгээд би Эдийн засгийн байнгын хороон дээр энэ аюулгүй энэ хог хаягдлаа тэр хөдөө аж ахуй дээр нь ярья аа. Асуух асуулт байна аа. Энэ гэрээний энэ өгсөн материалын 15 дугаар хуудсан дээр. Ноу хауны төлбөр хайгуул, олборлолтын арга туршлага, олон улсын стандарт төсөл хэрэгжүүлэгч компанид ноу хау хуваалцсаны төлөө Монголын тал ноу хауны төлбөрийг жилийн үйл ажиллагааны зардал болон жилийн нийт хөрөнгийн зардал гэж байгаа юм шүү Жавхлан сайд аа.

Хөрөнгийн зардлын 4 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг Француудад бид өгнө гэж байгаа юм. Боль л доо. Энэ чинь дахиад л Оюу Толгой ороод ирлээ шүү дээ. Тэд нар чинь зардал гаргах бөөн дур. Үйл ажиллагааны зардал гэж дээрэлхүүлэхгүй бүүр хөрөнгийн зардал гэж байгаа шүү дээ. Энийг би чуулганд ярих гээд даанч 1 дүгээрт цаг байхгүй.

Хоёрдугаарт энэ Эдийн засгийн байнгын хороогоор л ярих ёстой зүйл байх.

Хоёрдугаар асуулт. Үгүй ээ энэ чинь Францууд өөрөө өөрсдөө ухаж авах гэж байгаа шүү дээ. Энэ ураныг чинь. Өөрийнхөө ард түмнийг ногоон хямд эрчим хүчээр хангах гэж байгаа. Тэгээд ноу хаугаа өөрсдөө хэрэглэх гэж байгаа юм. Тэгээд бидэнд аваад үлдээгээд сургалт хийгээд байх юм юу ч байхгүй. Цагаан дээр хараар бичсэн юмыг би уншиж байгаа шүү.

Хоёрдугаар зүйл маркетингийн төлбөр гэж энэ 16 дугаар хуудасны доод талд Маркетингийн төлбөр гэж бүтээгдэхүүний борлуулалтын үнийн тодорхой хувьтай тэнцэх төлбөрийг авна аа. Бүтээгдэхүүний гэж байгаа шүү энэ Англи дээрээ бүүр тодорхой байгаа. Англи дээрээ бүүр их тодорхой. Монгол дээр их гөлөг төөрүүлэх юм ядаж байхад. Бүтээгдэхүүнийг борлуулахдаа үнэлгээний 2 хувийг рояалти авч байна даа Францууд бидний рояалти гэж нэрлэхгүйгээр 2 хувь авч байна даа. Хувьтай тэнцэх төлбөрийг ойлгоно. Үнэлгээний 2 хувьтай байх бөгөөд бүтээгдэхүүнийг цааш борлуулах нөхцөлийг бий болгох зорилготой. Энэ чинь Францууд авна шүү дээ. Өөрөө өөртөө маркетинг хийхдээ 2 хувийг цохино гэдэг чинь арай болохгүй л дээ. Ингээд л миний цаг 20 секунд болчихлоо.

Тэгэхээр 2 асуултдаа би хариулт авъя. Тэгээд хамгийн гол нь санхүүгийн тооцооллын 1, 2 дугаар хувилбарыг би дараа нь 1 минут нэмж авахаар авъя.

Эхлээд хариултаа авчихъя.

Р.Сэддорж: Хариулт Сангийн сайд 2 номер.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Хэлэлцээрийн явцад Монголын талдаа бид олж авч чадсан хэд хэдэн давуу тал өөрсдийгөө магтаад хэлэх юм бол ялалт хийсэн хэдэн зүйлүүдийн нэг маань энэ юм байгаа юм шүү Ганбаатар гишүүн ээ. Энийг их бүгдээрээ их зөв ойлголт үлдээх ёстой юм байгаа юм. Жишээ нь тэр маркетингийн зардал саяын таны ярьчихсан дурдаж байгаа маркетингийн зардал ноу хаугийн зардал энийг нөгөө талынхаа өгөөжид оруулж байгаа юм өгөөжид шүү. Бид нар Оюу Толгойтой харьцуулж ярих юм бол их ойлгомжтой харагдана. Оюу Толгойд болохоор яах вэ бүртгэлийн зардалдаа оруулаад өгөөждөө оруулаагүй байхгүй юу. Тэгэхээр зардлаа хязгааргүй өсгөх замаар цаад талдаа энийгээ өгөөж болгож авчхаад байгаа юм. Гэтэл албан ёсоор

өгөөждөө оруулдаггүй. Энэ удаа нөгөө талын 49 хувийн өгөөж дотор нь оруулчихаар манай 51 хувьтай ингээд уягдчихаж байгаа байхгүй юу. Холбоотой 2 лифт шиг. Энийгээ хязгааргүй өсгөж чадахгүй ийм зохицуулалтад орчхож байна гэсэн үг. Өөрсдийнхөө өгөөжийг өсгөх гэж байна гээд маркетингаа зардлыг өсгөх юм бол 49 хувийн өгөөж нэмэгдээд манай нөгөө 51 хувь ч гэсэн дагаад автомат цуг өсөөд явах юм байгаа юм. Тэгэхээр энийгээ шууд Оюу Толгой шиг тэгж өсгөх замаар зардлаа өсгөх замаар өгөөж хүртэх ийм боломжгүй болчхож байгаа юм. Энэ бол хэлэлцээрийн бидний хийж чадсан цаад талаар хүлээн зөвшөөрүүлж чадсан маш том амжилт гэж харж байгаа юм. Өмнөх гэрээнийхээ бид нар алдааг давтаж чадаагүй маш том урагшаагаа алхсан ийм зүйл болж байгаа юм.

Дээрээс нь тэр 4 хувь, 2 хувь гэдэг бол энэ татварын зорилготой асуудал огтоос биш. Энийг бид юу гэж зөвшөөрүүлж чадсан бэ гэхээр татварын зорилготойгоор хасагдах зардалд тооцохгүй шүү гэдгийг давхар зөвшөөрүүлж чадсан. Тэгэхээр энэ бүхэн бол одоо яг энэ гэрээний 10 гаруй бид нар жагсаалт гаргаж байгаа. Та бүхэнд дахиж мэдээлэл хүргүүлнэ ээ.

Бид нарын амжилт гаргаж чадсан ялж чадсан хэд хэдэн зүйлийн маань үр хойчдоо үлдээж байгаа нэг сайн талын нэг давуу тал маань энэ болж байгаа юм шүү. Энэ талаар мөн манай хөндлөнгийн шинжээч нар энэ дээр бас оролцож дүгнэлт гаргасан байгаа. Олон улсын шинжээчийн баг ажилласан байгаа. Тэд нарын үгийг сонсвол их хэрэгтэй болов уу гэж ингэж бодож байна.

Р.Сэддорж: 6 номер нэмж хариулъя.

Б.Хулан: Ажлын хэсгийн гишүүн Хулан. Ганбаатар гишүүний асуултад нэмэлтээр тодруулга өгье. Хөрөнгө оруулагчийн үр өгөөж Засгийн газрын хүртэх үр өгөөжийг гэдгийг бид нар хөрөнгө оруулалтын гэрээн дээр жагсаалтаар тохиролцсон байгаа. Олон улсын санхүүгийн зөвлөх байгууллагын зөвлөсний дагуу ноу хау, маркетинг пи гэдэг 2 төлбөрийг бид нар хөрөнгө оруулагч талын үр өгөөжид тооцохоор зөвшөөрүүлж чадсан. Хөрөнгө оруулагч талын үр өгөөжид төслийн нийт хугацаанд эзлэх хувийг авч үзэх юм бол 3.9 хувь нь ноу хау төлбөрөөр 5.9 хувь нь маркетингийн төлбөрөөр, үлдсэн хувь нь ноогдол ашгаар хөрөнгө оруулагчийн үр өгөөжид үр өгөөж хэлбэрээр очиж байгаа. Энэ нь юу гэсэн үг вэ гэхлээр ноогдол ашиг буюу тухайн бизнесийн байгууллага бүх зардал татвар тэр юмаа гаргаад хамгийн сүүлд үлддэг тэр хэсгээсээ хөрөнгө оруулалтаа нөхөж авах, үр өгөөжөө авах энэ боломжийг олгосон нь зардлыг хэмнэх хамгийн санхүүгийн менежментийн хувьд хамгийн үр ашигтай ажиллах энэ хөшүүргийг оруулж өгсөн гэж хэлж болно оо.

Монгол талын үр өгөөжид хамгийн нэгдүгээрт АМНАТ буюу төслийн нийт хугацаанд 37.6 хувь нь АМНАТ-аар 36.5 хувь нь ААНОАТ-аар, 11.5 хувь нь давуу эрхийн ноогдол ашиг хэлбэрээр, 5.2 хувь нь ноогдол ашгийн суутган татвар гэх мэт ийм бүтцээр ингэж явж байгаа.

Р.Сэддорж: Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Би бол цагаан дээр хараар бичсэн 4 хувийг зардлынхаа бүүр хөрөнгийн зардлын 4 хувийг өгнө. Мөн борлуулалтын худалдаж борлуулсан борлуулалтын 2 хувийг гэж рояалти гэсэн үг байхгүй юу. Тэрийг өгнө л гэж заасан. Тэгэхээр саяын ярьж байгаа энэ гоё тайлбаруудыг томъёоллоор нь аваад энэ гэрээний яг аль аль заалтад орсон бэ гэдгийг надад бүүр тодорхойгоор зааж өг.

Тэгээд би Төсвийн байнгын хороон дээр энийгээ яг тодруулж авчхаад дахиад асууна. Учир нь гэвэл би дараагийн 2 асуултаа би төсөв дээр асууя. Миний цаг дуусаж байх шиг байна.

Найзууд та нарыг ингээд муулах гээд юм уу асар их хөдөлмөрлөсөн, асар их чин сэтгэлээсээ Монголынхоо төлөө ажилласан. Гэхдээ биднийг нэгтгэдэг 1 том эрх ашиг байгаа шүү дээ. Цаад хөрөнгө оруулагчдын өмнө ер нь Монголын талыг нэг Африкийн нэг хэлтэрхий гэж бодож болохгүй шүү. Африкийг яаж цөлмөснийг чинь би мэднэ ээ. Тэгэхдээ Монголыг л лав биш. Тэгээд бидний эрх ашгийг өнөөдөр онцгой анхаарсан байх ёстой гэдгийг.

Р.Сэддорж: Хариулт 6 номер.

Б.Хулан: Ноу хау төлбөр, маркетингийн төлбөр гэдэгт юуг ойлгож байгааг гэрээний томъёолол хэсэгт оруулсан байгаа. Ноу хау-гийн төлбөр гэдэгт хайгуул, олборлолтын арга, аргачлал, туршлага, олон улсын стандарт, эрүүл мэнд, аюулгүй байдал болон байгаль орчны НС-ийн удирдлагын тогтолцоо компанийн нийгмийн хариуцлагын шилдэг туршлага, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналт, комплайнс болон аудитын журам зэрэг төрөл бүрийн хүрээ салбарт хөгжүүлэх, хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулах зорилгоор хөрөнгө оруулагч болон хамаарал бүхий этгээдийн зүгээс төсөл хэрэглүүлэгч компанид ноу хау хуваалцсаны хариуд нэхэмжлэх ноу хаугийн төлбөр шимтгэлийг ойлгоно уу гэж заасан байгаа.

Маркетингийн төлбөр гэдэгт бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2 хувь байх бөгөөд зах зээлийн богино хугацааны савлагааг нөхөх хувьцаа эзэмшигчдийн.

Р.Сэддорж: 1 номер нэмж хариулъя.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн татвартай холбоотой хэсэг дээр хариулт өгье. 5.4 дүгээр зүйл бүхэлдээ бид татварын суурийг багасгах ашиг шилжүүлэхийн эсрэг энэ татварын дүрмүүдийг яг олон улсын стандартын дагуу оруулна гэж заасан. Энэ 5.4.в дээр та харах юм бол ноу хау-ын төлбөр болон маркетингийн төлбөрүүдийг оролцуулаад бодит үнэ тодорхойлох зарчимд нийцүүлэх үүрэгтэй гэж бид нар тусгуулсан байгаа. Тэгэхээр татварын зорилгоор бид энэ 2, 4 хувь гэдгийг бол урьдчилж тохирсон зөвшөөрсөн юм байхгүй. Яг олон улсын болон Монголын хуулийн дагуу бодит үнэ болохыг тухай тухай үедээ тайлагнаж хамгаалах үүрэгтэй. Тэгэхээр бид нар энэ Оюу Толгойн том маргаан дээр гарч байгаа энэ асуудлыг бид энд сэргийлж тэр сургамжийг энд давтахгүйгээр тусгаж чадсан байгаа 5.4.в дээр.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Ганбаатар гишүүн та үг авч болно. Тийм Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Энэ протоколд тусгах ёстой зүйл шүү сая бол ингээд нэгэнт цагаан дээр хараар 4 хувь 2 хувийг өгнө гээд заачихсан байгаа. Гэхдээ энийг бол өгөхгүй юм гэж надад тайлбар өглөө. Учир нь өгөхгүй юм гэдэг Францын талд энэ өгөөжийн оролцох юм гэдэг энэ асуудлаа томъёоллоор нь яг ТЭЗҮ дээр туссан юм уу, гэрээний хаана нуугдаад байгаа юм гэдгийг нь надад зааж өгөөд тодорхой болговол энэ их буянтай зүйл ээ.

Р.Сэддорж: Нэмж хариулах хүн байгаа юу. Ажлын хэсэг. Эдийн засгийн яам нэг номер.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан. Өгөөжтэй холбоотой хэсэг бол 4.1 дээр байгаа гэрээний төслийн. 4.1.1 бол Монголын талын 4.1.1 бол нийт өгөөжийг хэрхэн тодорхойлж байгаатай холбоотой асуудал. Засгийн газрын өгөөж 51 хувь дор хаяж байх ёстой гэдгийг баталгаажуулсан заалтууд байгаа. Тэгээд тэрнээсээ доошоо 4.1.d дээр Монголын талын өгөөжид яг энэ энэ өгөөжүүдийг нэмээд Монголын талын өгөөж болно гэдгийг тодорхойлсон байгаа юм. Тэрний дараагийн 4.1.d дээр хөрөнгө оруулагч тал энэ 4, 5 өгөөжийг 5 зүйлийг нэмээд айлын талын өгөөж болно гэдгийг хатуу тодорхойлж өгсөн. Тэнд нь тэр маркетингийн төлбөр ноу хаугийн төлбөрийг тодорхойлж өгсөн байгаа юм 4.1.d тэгээд 4.2 дээр бол жил болгон энэ өгөөжийн тайланг төсөл хэрэгжүүлэгч компани гаргана. Түүнийг нь Засгийн газар.

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. Нэг номер.

Л.Энх-Амгалан: Хэрвээ хуримтлагдсан өгөөжөөр Монголын талын өгөөж айлын талын өгөөжөөс 51 хувиас доош орсон байвал нийт өгөөжийн 51 хувиас доош орсон байвал өгөөж тохируулах төлбөрийг тэр даруйдаа төсөл хэрэгжүүлэгч компани Монгол Улсын Засгийн газарт шилжүүлнэ гэсэн үүрэг амлалтууд мөн энэ 4.2 дээр орсон байгаа. Өгөөжийн тайлангийн 2 талаас тооцоо нийлж гарын үсэг зурж баталгаажуулна. Ингэснээр тохируулгын төлбөрийг хүлээж авах боломжтой болно.

Р.Сэддорж: Нэмж хариулах хүн байна уу? Болсон байна. Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Гэрээний төсөл маань хөрөнгө оруулалтын гэрээний төсөл анх яригдаж байснаасаа маш сайжирсан байгаа. Тэгээд ажлын хэсэг бас энэ нэлээн сайжруулсныг нь тэмдэглэж хэлэхийг хүсэж байна. Тэгэхдээ одоо бол энэ зөвшилцөнө гэж байгаа учраас санал гэхээсээ илүү дараагийн хөрөнгө оруулалтын гэрээ стратегийн ордуудтай холбоотой энэ том гэрээнүүд хийгдэх учраас энэнтэй холбоотойгоор нэг 2 асуулт байна.

Нэгдүгээрт нь болохоор худалдан авагч нь гэрээний хөрөнгө оруулалтын гэрээний нэг тал маань өөрөө худалдан авагч байгаа. Ийм харилцаанд орж байх үедээ борлуулалттай холбоотой заалт гэрээнүүдээ оруулж баймаар байна. Тэгэхээр өнөөдрийн коронатай хийж байгаа гэрээн дээр бол яг энэ борлуулалттай холбоотой заалт ерөөсөө энд байхгүй байгаа. Тэгэхээр энд тэндээс түүж уншиж байгаа. Тэгэхээр энэ борлуулалттай холбоотой заалтыг жишээлбэл Монголын хувийг АМНАТ-аар орлуулснаас болоод 34 байсныг 10 хувь болгосонтой нөлөөтэй холбоотой заалт жишээлбэл тэр бүтээгдэхүүн авах заалт дээр байгаа байхгүй юу 7.1.d дээр байна уу даа Засгийн газар Жишээлбэл бүтээгдэхүүний 10 хүртэл хувийг авч болно гээд. Хэрвээ жишээлбэл энэ яг бүтээгдэхүүн худалдан авалттай холбоотой. Яагаад гэвэл худалдан авагч чинь юу хөрөнгө оруулагч нөгөө тал маань бүтээгдэхүүнээ худалдаж авч байгаа учраас энэнтэй холбоотой заалтуудаа ер нь үнэ болон бусад харилцаатай холбоотой асуудлуудаа тусгасан ийм заалт ер нь оруулах ёстой гэж бодож байна цаашаа гэрээнүүд дээрээ. Тэгээд энэ жишээлбэл бусад хөрөнгө оруулалтын гэрээнүүд дээр тэр худалдан авагч нь хөрөнгө оруулагчдын нөгөө тал нь худалдан авч байгаа учраас. Тэгэхээр бид нар бол ер нь зөвхөн энэ төсөл ч биш Монголын экспортын гол бүтээгдэхүүнүүд дээр хил даваа л бол бид

нар олборлоод л, ухаад л, гаргаад л цаашаа бид нар ерөөсөө мэдлэг мэдээлэлгүй болчихоод байх юм. Энийгээ сайжруулах үүднээс эцсийн хэрэглэгч яг юу хүсдэг юм? Ямар шаардлага тавьдаг юм гэдэг зүйлүүдийг зөвхөн Орано гэхгүй нүүрс бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл экспортын чиглэлтэй заалтууд энэ хөрөнгө оруулалтын гэрээ юмнууд дээр тусгаж баймаар санагдаж байгаа.

Тэгэхээр энэ чиглэлээр жишээлбэл яагаад энэ заалтыг оруулаагүй байгаа юм? Хоёрдугаарт нь болохоор цаашдаа Үндсэн хуулийн 6.2 дээр болохоор өгөөжийн дийлэнх олонхыг ард түмэн хүртэнэ гэсэн, ноогдоно гэсэн ийм заалт байгаа. Тэгээд энэ дээр хэд хэдэн татварын заалтуудыг оруулаад Монголын талд 51 хувь болж байгаа. Жишээлбэл татвар гээд л орлогын албан татвар ноогдол ашгийн суутган татвар, гаалийн татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар ажлын байрны татвар гадаад ажилтны тэгээд НӨАТ, хүүгийн суутган татвар гэх мэт 7 татвар. Тэгээд ашигт малтмалын нөөц ашигласны татвар. Энэ суурь татварыг дээр нь ус ашигласны төлбөр ажил олгогчоос төлсөн НДШ, орон нутагт оруулах хөрөнгө оруулалт зэргийг оруулж тооцоод Монголын өгөөжийг гаргаж байгаа л даа. Тэгэхээр яах вэ энэ саяын тэр нөгөө энэ тооцоогоор бодохоор Монголын ноогдож байгаа 51 хувийн саяын хийсэн татварууд дээр дүнг нь харьцуулаад үзэхэд хэдэн хувь байгаа гэдэг тийм тоо хэлж өгөөч гэсэн ийм 2 асуулт байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Хариулт. 3 номер Учрал сайд. 1 номер.

Л.Энх-Амгалан: Би тэр өгөөжтэй холбоотой хэсэг дээр хариулья. Өгөөжийн жагсаалтыг яаж гаргасан юм бэ гэхээр яг хэлэлцээрийн явцад айлын талаас бол би тэр дүнгүүдийг нь яг гаргачхаад танд яг нарийн тоог нь хэлж өгье. Тэр татваруудыг яагаад оруулсан гэдэг дээр бол ойлголоо.

Р.Сэддорж: Нэмж хариулах хүн байна уу? Тодруулж асууя. Энхтүвшин гишүүн тодруулж асууя. 3 номер эхлээд хариулах юм байна. Учрал сайд.

Н.Учрал: 50 мянга тийм Энхтүвшин гишүүний энэ санал их чухал асуудал. Яагаад гэхээр бид нар бол нөгөө бүтээгдэхүүн хуваах борлуулалт дээр бол нөгөө 10 хувийн ноогдол ашиг авна гэдэг утгаараа бол борлуулалт дээр 10 хувиа эзэмшинэ гэдэг ийм ойлголт бол байгаа. Тэгэхээр цаашдаа бол яах вэ гэрээн дээр тэр борлуулалтыг нь тусдаа бүлэг хэмжээнд болгоод зохицуулах ёстой гэдэг энэ байр суурийг зөв гэж үзэж байна. Гэхдээ энэ удаа бол зөвхөн бид нар ноогдол ашгийн 10 хувиа авч байгаа учраас 10 хувийн борлуулалт хийх л ийм эрхтэй байна гэсэн үг. Тэгэхээр энэ чинь бол нэг жилд 2500 тонн үйлдвэрлэх боломжтой тэгээд түүний 10 хувийг нь бид борлуулах эрхтэй байна гэсэн үг.

Тэгэхээр хэрвээ одоо манайх өөрсдөө дотооддоо хэрэгцээгээ хангана гэх юм бол энэнээс бараг 10 дахин бага хэмжээний бид нарт тийм эрэлт байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол 10 хувийг нь 2500-ын 10 хувь 250 гээд үзэх юм бол энэ манай хэрэгцээнээс 10 дахин өндөр хэмжээ. Тэгэхээр борлуулалт дээрээ бол 10 хувиа эзэмшээд явах нь бол яг өнөөдрийн түвшинд хангалттай хэрэгцээг бол бүрэн хангана. Харин ч цаашдаа борлуулах ийм бололцоо бол бүрдэнэ. Дотоодын хэрэгцээгээ хангаад үлдсэнийг бол цаашдаа борлуулах бололцоо бол давхар бүрдэнэ гэж ингэж үзэж байгаа. Түрүүн бас Ганбаатар гишүүнийх дээр ч гарч байсан, таных дээр ч гарч байна. Ер нь бол энэ олон улсын санхүүгийн зөвлөх нөгөө ирүүлсэн зөвлөмж үүдийг бол бид нар яг тусгасан юм. Жишээ нь дотоодын санхүүгийн шинжээч нар ч гэсэн тэр нөгөө өгөөжийг тэнцвэржүүлэх буюу тэр 4.1

дээр заасан төслийн тэр яг шууд үр өгөөж гэж юуг хэлэх вэ гэдэг тухайлан заасан зохицуулалтууд бол энэ хэлэлцээний их сайн давуу тал.

Дээрээс нь төслийн үр өгөөжийг тооцохдоо түрүүн хэлсэн тэр 4.1-ийн d, c, a-д заасан яг хөрөнгө оруулагч төслөөс шууд үр өгөөж гэдэгтээ юуг ойлгох юм? Шууд Засгийн газрын төслөөс хүртэх шууд өгөөж гэдэгтээ юуг ойлгох юм бэ гэдгийг шууд өгөөж тэр гээд ингээд заасан. Тэрнээс биш нөгөө дам эсвэл шууд бусаар өртөх өгөөжийг бол бид нар өгөөжид огт тооцохгүй байгаа. Тэгээд ерөнхийлөхгүйгээр яг энэ 13 янзын төлбөр татвар бол нийлээд хөрөнгө оруулалт, Засгийн газрын үр өгөөж байна. Хөрөнгө оруулагч бол зөвхөн 4 янзын үр өгөөжийг та нар бол өөрсдийнхөө үр өгөөж гэж тооцно гэж ингэж оруулсан. Тэгээд ер нь бол энэ олон улсын CRA-ийн санхүүгийн зөвлөгөө. Байгаль орчин дээр бол тэр Жо Энержи, хууль дээр энэ Вайт энд Кэйс гээд олон улсын зөвлөхүүд бол ажиллаад тэгээд бид нар яг лист гаргаад одоо энэ гэрээний заалт бүр дээр энэ аль аль байгууллагын зөвлөгөө юм, яагаад энэ заалтуудыг оруулсан юм бэ гээд тухайлан тайлбаруудыг бол бэлдсэн байгаа.

Тийм учраас зүйл заалтаар хэрвээ гишүүд асуух юм бол бид нар яг нэмээд тухайн заалтыг ямар нөхцөл үндэс шаардлагаар оруулсан бэ гэдгийг хэлээд явах бололцоотой гэдгийг хэлье. Ингээд нэмж хариулах байх. Хулан зөвлөх.

Р.Сэддорж: 6 номер нэмж хариулъя.

Б.Хулан: Ажлын хэсгийн гишүүн Хулан. Энхтүвшин гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье өө. Гэрээний нэр томъёо хэсэгт бүтээгдэхүүний борлуулалтын үнэ гэдгийг тусгасан байгаа. Борлуулалтын үнэ гэдэгт UXC болон Трэйд Тек үнэ нийтэлж байгаа компанийн сүүлийн зургаан 7 хоногийн ханшийн дунджийг авна гэсэн. Тэгээд борлуулалтын гэрээн дээр төсөл хэрэгжүүлэгч компани болон бүх хувьцаа эзэмшигчтэй байгуулах, худалдах, худалдан авах гэрээнд энэхүү гэрээнд тодорхойлсон бүтээгдэхүүнийг борлуулалтын үнэ гэсэн тодорхойлолтыг тусгана гэж заасан. Тэгэхээр хэдий холбоотой этгээдийн хооронд бүтээгдэхүүн борлуулах гэрээ явж байгаа ч гэсэн 1 дүгээрт нь бол энэ үнийг ашиглана.

Хоёрдугаарт Монгол тал болон Орано тал ижил нөхцөлөөр бүтээгдэхүүнээ ижил үнээр ижил нөхцөлөөр бүтээгдэхүүнээ борлуулна гэж тусгасан.

Гуравдугаарт Монгол тал бүтээгдэхүүнээ худалдаж авах дээр 10 хувьдаа мөн маркетингийн хи пи авахаар ингэж тодорхойлсон байгаа.

Хоёр дахь асуулт буюу тэр хувь хэмжээн дээр тайлбарлая. Энэ нөгөө татвар болон ноогдол ашиг зэргийг тухайн хост каунтри буюу Засгийн газрын үр өгөөжид тооцдог энэ аргачлал нь бол Монгол Улсад ганцхан төдийгүй олон улсад Филиппин, Эквадор, Танзан гээд бусад улсуудад бас ингэж хэрэглэдэг ийм арга аргачлал ОУВС-аас гаргасан ийм аргачлал байдаг аа. Энэ аргачлалын дагуу тооцоход Монгол талын тэр 51 хувийг гүйцэлдүүлж байгаа үр өгөөж гэдэг дээр АМНАТ бол 37.6 хувийг нийт авч байгаа үр өгөөжөө 100 хувь гэж үзэх юм бол АМНАТ 37.6, ААНОАТ 36.5. давуу эрхийн ноогдол ашиг 11.5 ноогдол ашгийн суутган татвар 5.2 гаалийн албан татвар 2.4, НДШ 1.5, тусгай зөвшөөрлийн төлбөр 0.3, үл хөдлөхийн татвар 1.3, өгөөж тэнцвэрцүүлэх механизм үүнийг бид нар ингээд 75 дээр тооцоход 80 дээр тооцоход 2.3 гээд ингээд нийлбэр өгөөжийг бүрдүүлж байгаа юм аа. Энэ тооцооллыг танд явуулах боломжтой.

Р.Сэддорж: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Гол нь нөгөө дараагийн хөрөнгө оруулалтын гэрээнүүд дээр нөгөө байгалийн баялгийн дийлэнх олонх нь ард түмэнд ноогдох ёстой гэдэг зарчим дээр жишээлбэл саяын энэ татвар хураамжуудыг ингэж тооцох ийм жишиг тогтоож байна гэсэн байгаа учраас энийг жоохон хүн тодорхойлох үүднээс яг энэ талаараа бусад гэрээнүүд дээр ч гэсэн жишиг болгох учраас энийгээ нэлээн тодорхой хэлээд явчихвал зүгээр юм уу гэсэн санаа байгаа.

Хоёрдугаарт нь тэр борлуулалттай холбоотой гэрээг яах вэ энд тэнд нь оруулах биш чухалчилж яагаад гэвэл худалдан авагч нь нэг тал байгаа учраас би энэ цаашдаа бусад гэрээнүүд дээр жишээлбэл нүүрстэй холбоотой гэрээн дээр ч гэсэн хамтарч ажиллах гэрээн дээр гэрээний нэг тал маань худалдан авагч өөрөө аваад цаашаа борлуулах учраас тэр борлуулснаас цааш юу болоод байгаа юм тэр борлуулалтаас цаашаа юу болоод байгаа гэдгийг бид нар сайн мэддэг байх үүднээс энийгээ оруулаарай гэсэн тийм санаа байгаа юм. Зүгээр нэмээд нэг асуулт байна. 500 гэхисэн байсан хөрөнгө оруулалт гээд. Тэр нь нийт хөрөнгө оруулалт нь 1 тэрбум 650 гэхисэн байсан. Энэ нэмэгдэж байгаа 1 тэрбум 150 нь яаж хөрөнгө оруулалтууд хийгдэх вэ?

Р.Сэддорж: 3 номер Учрал сайд.

Н.Учрал: Тэгээд Энхтүвшин гишүүний энэ санал бол маш зөв л дөө. Та бол хувийн хэвшилд энэ борлуулалт хариуцаж байсан учраас компанийн үйл ажиллагаанд энэ борлуулалт ямар чухал вэ гэдгийг мэдэж байгаа. Тэгэхээр үнэхээр нөгөө бид нар нөгөө загвараа сонгочихсон. Нөгөө төрийн эзэмшлийн 34 хувь дээр бид оролцоод, менежментэд оролцъё, ачаагаа хамт үүрье гэхисэн бол нөгөө борлуулалт дээрээ юугаар тээвэрлээд хаагуур явуулаад аль ложистикоор шийдээд ингээд аль аль улс руу гаргах вэ гээд ингээд магадгүй оролцоод явах байсан байх.

Бид нар загвараа сонгохдоо бид ерөөсөө л 10 хувийн ноогдол ашиг дээрээ бусдыгаа АМНАТ, өссөний мэдэх АМНАТ-аар орлуулаад 50 дээр 50 нэмэх 1-гээ хангуулъя гээд ингээд тохирчихсон учраас бид бол зөвхөн тэр нөгөө борлуулалт дээрээ 10 хувь дээрээ л оролцоод бусдыг нь тэд нар яаж гаргана вэ ямар ложистикоор явуулна вэ гэдэг нь бол тэдний асуудал учраас тийм мэдээ гэрээнд нарийвчлан заагаагүй байж болох энэ тохиолдолд гэхдээ 10 хувь бол түрүүн миний хэлснээр зүгээр.

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя 3 номер. Учрал сайд.

Н.Учрал: Тэгэхээр түрүүний хэлснээр одоо нөгөө манай давуу эрхийн 10 хувийн хувьцаа чинь өөрөө нөгөө хориг тавих эрхтэй ийм ТУЗ-д нэг хүн суулгаад ингээд оролцох хэдий ч тэргүүн ээлжид ноогдол ашгаа хүртэх хэдий ч бид нөгөө санхүүгийн хариуцлага хүлээхгүй ямар нэгэн байдлаар менежментэд нь оролцохгүй учраас зөвхөн 10 хувийнхаа борлуулалт дээрээ л оролцъё гэдэг ийм л зарчимтай учраас 90 хувиа тэд яах дээр бид нарийвчилж заах нь зохимжгүй л гэж ингэж үзсэн юм. Энэ тохиолдолд би нэгэнт загвараа сонгосон учраас. Зүгээр 10 хувь бол тэр жилийн 250 мянган тонн гээд ингээд бодоод үзэхээр 10 хувиа авна. Манайхаас 10 дахин гээд байгаа нь жилд нэг 27 мянган тонны хэрэгцээ манайд байгаа юм байна лээ л дээ дотооддоо хангая гэвэл. Тэгээд түүнээс 10 дахин их нөөц бид нар авах гээд байна шүү дээ 10 хувиараа тиймээ? Тэгэхээр дотоодыгоо ч хангачихна.

Гадагшаа тэр асуудлыг бол тухайн үед хувь нийлүүлэгчдийн гэрээгээрээ нарийвчлаад.

Р.Сэддорж: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Сайн байцгаана уу энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр аливаа томоохон төсөл нэн ялангуяа уул уурхайн томоохон төсөл урагшаа явахын тулд ийм нийгмийн зөвшилцөл хэрэгтэй. Тэгээд бүх хүмүүсийн дунд нэг ийм консенсус үүссэн байх хэрэгтэй. Тэгэхээр энэ Засгийн газар одоо ингээд энэ томоохон төслүүдээ хөдөлгөө явуулъя гэж байгаа бол яг үүн дээр маш сайн анхаарах хэрэгтэй санагдаж байгаа юм л даа. Тэгэхээр одоо жишээлбэл энэ Оранотай холбоотой гэрээ хэлэлцээрүүд бол ингээд л яах вэ өмнө нь орж ирээд л оны өмнө ч гэсэндээ яригдаад л явсан. Гэлээ гэхдээ яг улсын Улсын Их Хурлын гишүүдийн гар дээр бол яг энэ гэрээний төсөл ном нь бол нэг 10-аад хоногийн өмнө, ди парламент дээр энэ төсөл маань 3 хоногийн өмнө тавигдсан байгаад байгаа юм.

Тэгэхээр бол нөгөө яг олон нийтийн хувьд ялангуяа мэдээлэл жаахан багатай. Яг ямар ямар механизмууд явж байгаа юм? Яг энэ гэрээн дээр Монгол Улсын эрх ашиг хэрхэн яаж хамгаалагдаж байгаа юм гэдэг дээр яг тэр төрлийн коммуникац маш жоохон сул хийгдэж байна гэж харж байгаа. Тэгэхээр бид нар бол аливаа энэ томоохон төслүүдээ ингээд ийм үр ашигтайгаар явуулаад тэгээд энэ дээр элдэв янзын нэг ийм улс төржсөн хэрүүл маргаан үүсгэхгүйн тулд бол энэ коммуникацаа маш сайн хийх ёстой байгаад байна л даа. Тэгэхээр нөгөө иргэддээ аягүй сайн тийм тайлагнах ёстой байгаад байгаа юм.

Тэгэхээр би бол өнөөдөр ингэж бас яаруу сандруу хэлэлцэж байгаад бол дахиад л дурамжхан байгаад байгаа юм.

Ер нь бол энэ Улсын Их Хурлаас чинь сүүлийн 6 сар бол ингээд л ямагт л нэг ийм яаралтай асуудал хэлэлцээд л цаг хугацааны хайчинд орсоор л явж байна шүү дээ. Тэгэхээр нөгөө энэ нь магадгүй нөгөө ийм итгэлцэл бүрдүүлэхгүй цаашид нийгэмдээ ойлгогдохгүй ингээд ийм асуудлууд үүсэх магадлалтай гэдэг дээр нь маш ихээр санаа зовж байгаа юм. Тэгэхээр Засгийн газрын гишүүдээс одоо энэ ажлын хэсгээс хүсэх зүйл нь юу вэ гэхээр дараа дараачийн зүйл дээр энэ коммуникацын асуудал дээрээ анхаараач ээ. Ингэж битгий цаг хугацааны хайчинд оруулж бай гэсэн нэг тийм санал бол байгаад байгаа юм аа. Тэгээд сая болохлоор оны өмнө жишээлбэл олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр энэ Монгол Францын энэ төслийн гэрээ эцэслэн байгуулагдлаа гээд л нэг манай талаар нэг тийм алдаатай мэдээлэл явчихсан юм уу даа гэх мэтчилэн ерөнхийдөө зөвхөн дотооддоо ч биш, гадаад талдаа ч гэсэн тийм коммуникацын алдаанууд гаргаад байна аа.

Ингэхээр чинь болохоор хүмүүс хардаж сэрдэх нь аргагүй ээ. Бид нар бол ялангуяа энэ ураны төсөл дээр хүмүүсийн болгоомжлол маш өндөр байгаа. Тэгэхээр энэ нөгөө нарийн сайн тайлбарлаад энэ мэдээлэл солилцоогоо маш сайн явуулах ёстой гэж харж байгаа юм. Тэгэхээр миний бол яг энэ төслийн хувьд болохоор нэг санаа зовоод байгаа гол зүйл нь болохоор энэ төсөл дээр бид нар анх одоо энэ нөгөө стратегийн орд газарт хувь эзэмших тэр төрийн 34 хувийг орлуулах механизмыг анх удаа ашиглаж байна шүү дээ. Тэгэхээр энэ утгаараа бол яг энэ нэг орлуулж байгаа байдлаараа энэ төсөл маань прецедент болох гээд байгаа юм.

Тэгэхээр яг энэ дээр л бас их санаа зовоод байгаа юм л даа. Тэгэхээр яг одоо энэ гэрээний төслийг хараад үзэхлээр ТУЗ-ийн гишүүн нь 10 хүн байна. Тэр дундаа нэг ТУЗ-ийн гишүүнийг Монголын талын талаас томилно гэгчихсэн байгаад байгаа юм. Тэгээд өмнө нь асуухаар болохоор энэ ТУЗ-ийн гишүүн маань аливаа асуудал дээр хориг тавих эрхтэй байна гэсэн.

Р.Сэддорж: Нэг минут нэмж өгье. Жаргалан гишүүнд.

Б.Жаргалан: Монголын талаас ТУЗ-д орсон гишүүн маань аливаа асуудал дээр хориг тавих эрхтэй байна аа. Энэ бол гэрээний маш сайн заалт болсон гэсэн мэдээлэл өгч байсан. Гэхдээ яах вэ энэ хориг тавих эрхийнх нь цар хүрээг нь яг одоо гэрээнээс харахад жишээлбэл дүрэм болон хувь эзэмшилд аливаа өөрчлөлт орох, өөрчлөн байгуулах, татан буулгах, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, баталгаа гаргах зэрэг асуудлаар хориг тавих эрхтэй гэгчхэж байгаа байхгүй юу. Ерөнхий асуудлаар. Угаасаа одоо энэ гэрээгээр баталгаажсан зүйлүүд дээр хориг тавих чинь бол нэг их тийм айхтар угаасаа лицензийг шилжүүлэх энэ тэр асуудал дээр хориг тавих бол нэг их тийм айхтар ач холбогдолтой биш гээд ч хараад байгаа байхгүй юу. Би юу гэж бодоод байсан бэ гэхээр жишээлбэл ТЭЗҮ-д өөрчлөлт оруулах ч гэдэг юм уу эсвэл тухайн жилийн төлөвлөгөө энэ тэр дээр юунаас гадуур асуудал байх юм бол ийм үйл ажиллагаатай холбоотой зүйл дээр хориг тавих боломжтой гэж хараад байсан юм аа? Тэгэхээр энэ дээр бас нэг тайлбар өгнө үү? Тэгээд энэ ТУЗ-ийн гишүүнийг зөвхөн нэг биш нэгэнт бид нар орлуулах механизм ашиглаж байгаа юм чинь одоо нэг биш 2 хүн ч юм уу тийм төрлийн хэлэлцээрүүд ер нь хийсэн үү? Хариулт 3 номер Учрал сайд.

Н.Учрал: Тийм. Би ч бол нэг их тийм физикч хүн биш. Нэг уул уурхай би мэдэхгүй л дээ. Би ер нь Гашуун Сухайтад очиж үзээгүй юм аа. Би тэр Дорноговь Улаанбадрахад ч гэсэн очиж үзээгүй. Миний хувьд бол. Тэгээд би тэр Француудтай нэг хоолонд ч ороогүй. Би нэг кофе ч уугаагүй шүү дээ. Тийм учраас нэг тийм дүлий байдлаар л дуусгачихъя л гэж бодоод байгаа юм. Тэгэхгүй бол энэ их аюултай юм байна. Тэгээд 2015 оны балаг одоо хүртэл яригдсаар л байна. Тийм тэгээд тэрийг бид биш дэлхий яриад олон улсын шүүх шийдчихлээ л дээ. Тийм учраас Монголын төрд бас нэг ингээд улс орны эрх ашгийн төлөө нэг их тийм бид нар чинь залуу хүмүүс нэг их тийм хар буруу түүхгүй нөхдүүд ийм гэрээ хийчихвэл зүгээр юм байна гэж би бодоод байгаа юм.

Тийм учраас энэ ажлын хэсэгт ч гэсэн ер нь дандаа залуучууд орсон. Тэгээд Оюу Толгойн гэрээний үеийг бодвол тэр цаг үеэс хойш бидний үеийнхэн энэ Жаргалан гишүүн тэгээд манай энэ Батнайрамдал гээд л бид нарын энэ үеийнхэн чинь бас мэдлэг боловсрол эзэмшээд бас нэг гадаад дотоодуудтай нэг хэд 3 үг хэлдэг болсон байна шүү дээ. Тэгээд бидний хажуугаар чинь энэ сайн санхүүгийн шинжээч нар төрөн гарсан байна. Олон улсад хэлэлцээ хийх ийм чадамжтай нөхдүүд гарч ирсэн байна. Хамгийн сайн нь энэ нөхдүүдэд ямар нэгэн хар буруу түүх ашиг сонирхол байхгүй юм байна. Эд нарт ерөөсөө л улс орныхоо төлөө тэр Үндсэн хуульд заасан 6.2.51-ийг л хийчихсэн л гэдэг зориг байсан. Тэгээд л санхүүгийн схемээ хийгээд л өөрсдөө гэрээнийхээ драфтыг боловсруулаад л ингээд л хийсэн. Тийм тэгээд эднээс 27 жил шүү дээ. Анхааралтай ажигласан ажлын хэсэг ажилласнаа яривал тэр ажлын хэсгийнхнийг цуглуулбал энэ доод талын Төрийн ордны Их танхим дүүрэх байх аа. Үе үеийн ажлын хэсгийнхийг цуглуулбал.

Тэгэхээр одоо хэдүүлээ энэ Цэнгүүнийгээ эмээ болохоос нь өмнө асуудлаа шийдэхгүй бол бид 2 өвөө эмээ болчихсоны дараа тэгээд л болоогүй байна л гээд л суух л байх л даа. Энэ чинь ингэсэн л дээ. Цөмийн энергийн хууль батлагдсан манай Их Хурлын Пүрэвдорж дэд дарга, Пүрэвдорж гишүүн ахлаад ингээд сая хууль оруулж ирсэн. Хуулийнхаа үеэр гэрээгээ та бүхэнд танилцуулсан. Тэгээд сая гишүүдийн санал Уянгахишиг гишүүн их сайн саналууд хэлсэн. Түүнтэй холбогдуулаад энэ сүүлийн энэ гэрээн дээр нэг энэ гишүүдийн оруулсан саналуудыг бид нар цаад талдаа хэдэн шөнө л хуралдаж байж нэг зөвшөөрүүлээд тэгээд л ингээд л эцсийн байдлаар зөвшилцье гээд л оруулж ирж байгаа. Тэгээд тэрнээс биш бид нарт ганц л зарчим байгаа. Тэр 51-ийг л нэг хангуулчихъя л гэж. Тэгээд хамгийн сүүлд том ажлын хэсгийн ахлагчийн хувиар би энэ 5 сайдын ахалсан ажлын хэсгийн ахлагч нар буюу 5 сайдаас асуусан. Та байгаль орчны чиглэлээр Хаппи байна уу гэж би Одонтуяа сайдаас асуусан. Би доод дэд ажлын хэсгийн энэ Байгаль орчны яамныхныг бүгдэнгээс нь асуусан та нар итгэлтэй байгаа биз гэж. Тэрнээс би нэг их байгаль орчин мэддэгтээ биш.

Тэгээд Эдийн засгийн сайдаас асуусан. Доод бүх бүрэлдэхүүнийх нь саналуудыг сонссон. Хууль зүйн сайд гэрээн дээрээ ямар байна вэ? Энэ зөвлөх үйлчилгээний компаниуд чинь хэр ажилласан бэ? Би бүх хурлуудыг нь хийсэн. Ажлын хэсгийн зүүмийн хурал протокол бүгд тэмдэглэлд үлдлээ. Энэ түүх болж үлдэх байх тийм учраас хожуу олон жилийн дараа энд ажилласан хүмүүсийн үг яриа, хэл, ажлын хэсгийн протокол бүгд ингэж бичигдэж үлдэнэ.

Тийм учраас процессын дагуу бол хууль, гэрээ ингээд л зарчмаараа л явж байгаа Их Хурал бол зөвшилцөх дээр бол нэг ёсондоо зөвшөөрөх гэхээсээ илүү энэ нөгөө зөвшилцөх. Өнөөдөр бол чуулганаар орох эсэхийг Аюулгүй байдлын байнгын хороо шийдээд л ингээд л явна. Гишүүдийн л бүрэн эрхийн асуудал.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн дарга Пүрэвдорж дарга нэмж хариулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Цөмийн энергийн хууль стратегийн орд газрын төрийн эзэмшлийн хувийг АМНАТ болон бусад татвараас суутган орлуулах Их хурлын тогтоолын төсөл Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн өөрчлөлт зэрэг 3 хууль яг энэ Ораногийн хэлэлцээг явуулахын тулд одоо батлагдсан байгаа. Тэгээд сүүлийн 2 хууль буюу энэ хууль тогтоомж 2-ыг дагалдуулаад хэрвээ АМНАТ-аар орлуулах тохиолдолд яг хэлэлцээ бол ийм байна гэдэг ийм хувилбарыгаа бол 12 сарын 26-ны өдөр хуулиудаа тогтоолуудаа дагалдуулаад өгсөн. Тэрнээс хойш 15 хоногийн хугацаа өнгөрч байна. Тэгэхээр энэ дээр бол нэгэнт л хууль.

Р.Сэддорж: Пүрэвдорж дарга гүйцээж хариулъя.

Б.Пүрэвдорж: Нэгэнт л цөмийн энергийн хууль болон нөгөө сүүлд орсон хууль, тогтоолын төслийн дагуу хууль батлагдаж байгаа учраас яг тэрнийгээ дагалдуулсан төсөл орж ирж байгаа. Тийм учраас энэ дээр бол Засгийн газар тодорхой бүх ТЭЗҮ болон бусад бүх хуулийн дагуу энэ хэлэлцээг оруулж ирж байгаа учраас богино хугацаанд орж ирлээ гэдэг энэ хугацаа байсан шүү. 15 хоногийн хугацаанд энэ Их Хурлын гишүүд хангалттай танилцах, энэний дотроос янз янзын асуудалтай байгаа бол бүрэн тавих ийм боломж байгаа. Тэгэхээр энэ дээр яг энэ хэлэлцээтэй холбоотой тодорхой хэмжээний санал байгаа бол протоколд тусгая.

Р.Сэддорж: 3 номер Учрал сайд.

Н.Учрал: Би түрүүн Жаргалан гишүүний асуултад дутуу хариулсан. Төрийн эзэмшлийн хувьцаа гээд гэрээний 7 дээр 7-гийн түрүүн таны уншсан Засгийн газар нь төсөл хэрэгжүүлэх компанийн дүрэм хувь эзэмшилд аливаа өөрчлөлт оруулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, баталгаа гаргах, түүнд орох нэмэлт, өөрчлөлт зэрэг асуудлаар хориг тавина гээд орсон. ТЭЗҮ-д өөрчлөлт оруулах бол компанийн дотоод асуудал биш. Тэр Аж үйлдвэр, эрдэс баялгийн зөвлөл буюу төрийн байгууллагын эрх. Тэгэхээр ТЭЗҮ-д бол энэ хөрөнгө оруулагч тааруулбал яагаад ч өөрчлөлт оруулах төрийн байгууллагын эрхгүй гэж чадахгүй. Хувь шилжүүлэх тэр асуудал бол угаасаа дүрмийн хүрээнд заавал шийднэ. Дээрээс нь зээл авах асуудал бол энэ гэрээн дээр зээл авах тохиолдолд ТУЗ-ийн 100 хувийн шийдвэрээр гээд заачихсан юм. Тэгэхээр манай нөгөө нэг ТУЗ-д суух гэж байгаа хүн бол хориг тавих эрхтэй дээрээс нь зээл авахгүй гээд нэг хүн эсэргүүцэхэд л зээл авахгүй.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Яах вэ сая манай ажлын хэсгийнхэн жаахан буруу ойлгочих шиг боллоо. Энэ Их Хурлын гишүүд гэрээтэй танилцах нь чухал гэдэг утгаараа биш ер нь бид нар нийгэмд нэг ийм зөвшилцөл үүсгэх нь чухал. Тэгээд энэ бичиг баримтуудаа нөгөө эртхэн шиг ди парламент дээрээ тавиад ч гэдэг юм уу нийгмийн хүрээнд бас хүмүүст, иргэддээ мэдээлэл өгөх нь чухал гэсэн тийм зүйл яриад байгаа юм л даа. Түүнээс биш нөгөө сайд нар тийм тийм сайд нар болж байна, бүтэж байна тэ, гишүүд болж байна бүтэж байна гэж хэлэх нэг өөр хэрэг. Монголын ард түмэн энэ дээр ингээд нэг итгэл төгс энэ асуудал дээр бас нэгдсэн байр суурь бүрдүүлэх тэр боломжийг нь бий болгох нь чухал гэж харж байгаа. Тэгээд гялс нэг асуулт асуухад энэ тэрбум 600 сая амдолларын хөрөнгө оруулалт гэж байгаа шүү дээ тиймээ? Тэгээд эхний 4 жилд нь 500 сая гээд байгаа юм. Тэгээд нөгөө араас нь болохоор 1.1 нь орж ирнэ гээд байгаа юм. Сая Энхтүвшин гишүүн дурдах шиг боллоо. Тэгэхээр нөгөө энэ 1.6 чинь яг нөгөө эхний нөгөө анхны хөрөнгө оруулалт уурхай ашиглалтад орох хүртлээ хийгдчихгүй байсан юм уу?

Тэр цаад талын мөнгөнүүд нь яг юунд зарцуулагдаж байгаа юм.

Р.Сэддорж: 3 номер Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Би ойлголоо Жаргалан гишүүн ээ. Тэгээд өнөөдөр их сонин мэдээлэл авлаа. Одоо энэ чат чипи дээр бичихээр ч гэсэн дэлхий дахинд ураны гэрээг ил болгосон анхны улс боллоо. Монгол Улс яагаад гэхээр ер нь дэлхийд ер нь ураны гэрээ ил байдаггүй юм байна. Тэгээд Монгол Улс бол их ил тод улс гэдгээ харуулж байх шиг байна. Ди парламент дээрээ тавьчихсан улс гэдэг бол гайхамшиг юм гэж дэлхий нийт цочирдон хүлээж авч байна. Яагаад гэвэл ийм стратегийн ийм том гэрээг ингэж ил хэлэлцэж нээлттэй ярьж хүн болгон саналаа хэлж бүгд эдийн засагч болж бүгд уул уурхайн, физикийн эрдэмтэн судлаачдын дүрд орж ярина гээд их ил тод хэлэлцэж байна гэж. Тэгэхээр бид их ил тод байгаагаа харуулж байгаа. Тэгээд цаашдаа иргэддээ мэдээлэл сайн өгье.

Р.Сэддорж: Нэг номер Эдийн засгийн яам.

Л.Энх-Амгалан: Үлдсэн 1.1 тэрбум доллар яг хөрөнгийн зардал нь бол энэ нөгөө технологийнхоо хувьд бол ингээд газар руу маш олон тийм нөгөө торлол үүсгэсэн тийм хөрөнгө оруулалтууд хийгдэнэ. Нүх рүү тийм нөгөө уранаа гаргаж ирэх хоолойнууд, тэр хоолойных нь ерөнхий элэгдлийн зардал нь 5-аас 10 жилийн хугацаатай байгаа юм. Тэгэхээр төслийн нийт хугацаа нь яг ТЭЗҮ-ийнхээ дагуу энэ 1.1 тэрбум доллар бол хуваарийнхаа дагуу хийгдээд явна. Хөрөнгө оруулалтын гэрээн дээрээ бол ТЭЗҮ дээр яаж тусгагдсаны дагуу энэ төслийн үйл ажиллагаа зохион байгуулагдана гэж орсон байгаа.

Тэгээд л ТЭЗҮ батлагдахаар энэ тоонууд хэзээ яаж хөрөнгө оруулалтууд хийгдэх нь илүү тодорхой болчихоод явна гэсэн үг.

Р.Сэддорж: Энхцэцэг гишүүнийг нэмээрэй. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: Ураны талаар хөрөнгө оруулалтын гэрээг анх удаа байгуулж байгаа гэхдээ гуравдагч хөрштэй НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн 5 орны нэг. Франц улстай гэдэг энэ зүйлийг харгалзан үзэж Монголчууд Монголын парламент хэлэлцэж байгаа гэж би хувьдаа ойлгож байгаа. Тэгээд тийм учраас энэ гэрээнээс дараа дараагийн олон гэрээ байгуулагдах үндэс, ач холбогдол бол шалтгаална аа. Дэлхий нийтэд энэ газрын ховор элемент, ашиг өгөөж өндөртэй энэ металл ашигт малтмал гээд энэ зүйлүүдэд хөрөнгө оруулах сонирхол цаашдаа Монгол Улсад улам бүүр нэмэгдэх ийм ирээдүй магадлал бидэнд байгаа.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд ард түмнээс сонгогдсон парламентын гишүүнийхээ хувьд энэ зүйл дээр үзэл бодол байр сууриа илэрхийлэх нь би бол чөлөөтэй гэж бодож байна. Мэргэжил үл хамаараад энд ард түмнээс сонгогдсон ард түмний мандаттай төлөөлөгчийн хувьд заавал хэлэх ёстой. Энийг харин Засгийн газар, гэрээ байгуулах эрх бүхий албан тушаалтан эрх бүхий байгууллага тусгаж авч хэрэгжүүлэе гэж байгаад нь би их баяртай байна. Тэгээд энэ танилцуулга дээр Их Хурлын гишүүдийн саналыг харгалзсан. Ялангуяа тогтворжуулалтын хувьд үүн дээр байгаль орчныг хамгаалах тал дээр гишүүдийн ажил хэрэгч саналыг тусгасан гэдгийг бол зөв байна гэж би хувьдаа бодож байна. Тэгээд нэг 4 зүйл хэлье. Энэ гэрээг зөвшилцөж байгаа учраас 1 дүгээрт лиценз, компанийн хувьцаа шилжүүлэх эсэх дээр Засгийн газар онцгой анхаарч зөвшөөрдөг байгаарай гэдгийг би чин сэтгэлээсээ хүсэж байна. Би ярианыхаа эхэнд хэлсэн. Франц улсын хөрөнгө оруулалттай учраас үүнийг дэмжиж байгаа гэдгийг цаг ямагт санаж байх хэрэгтэй гэдгийг би онцгойлон хэлж байгаа юм. Гуравдагч хөрш аюулгүйн 5 орны нэг гэдэг утгаар нь. Тэгээд энийг ерөөсөө умартаж болохгүй гэдгийг л би онцгой анхааруулж протоколд тэмдэглүүлэе гэж бодож байна, нэг.

Хоёрдугаарт нь энэ бүтээгдэхүүнийхээ 10 хүртэл хувийг худалдан авах гээд гэрээн дээр оруулчихсан. Би энийг өөрчлөөч гэдгийг хүсэж байна. Яагаад гэвэл энэ өөрчлөхгүй бол ерөөсөө болохгүй. Яг энэ найруулгаар бол 10 хүртэл хувийг заавал авахаар оруулчихсан байгаа юм. Зүй нь юу гэж оруулах вэ гэхээр 10-аас доошгүй хувийг худалдан авах эрхтэй гэж оруулах ёстой. Өөрөөр хэлбэл бид нар 10 хувийн хувьцаа давуу эрхийн хувьцаа эзэмшиж байгаа учраас 10 хувийг хамгийн багадаа 10 хувийг цаашдаа авах боломжтой. Гэхдээ авахгүй ч байж болно. Эрхтэй байхаар. Ингэж найруулахгүй бол энэ бол тийм заавал авах ёстой юм шиг эсвэл 10 хүртэл хувийг 0.5 хувийг ч юм уу 0.01 хувийг ч юм уу авах юм шиг ийм утгаар ойлгогдож байна аа.

Гуравт нь орон нутгийн ажлын байр.

Р.Сэддорж: Нэг минут Бадамсүрэн гишүүнд нэмж өгье.

М.Бадамсүрэн: Гуравт нь орон нутгийн иргэд 5 хувиас доошгүй гэж байна. Энэ бол бага байна аа. Орон нутгийн иргэдийг дийлэнх нь байх ёстой гэдэг заалтыг энэ дээр оруулж өгөөч гэж хүсэж байгаа юм. Яагаад гэхээр 1600 ажлын байр бий болно гэж байна. Цаашдаа энд суурьшлын бүс байгуулах ёстой өөрөөр хэлбэл ростероор буюу 14, 14 хоногоор явдаг биш. Энд Багануур шиг, Эрдэнэт хот шиг сургууль, цэцэрлэг, нийгэм, соёлын төвтэй уурхайчин залуу тэнд ажилладаг. Эхнэр нь нийгэм соёлын салбарт ажилладаг. Ийм суурьшлын бүс байгуулах ёстой гэж бодож байна, гурав.

Дөрөвт нь туслан гүйцэтгэх ажил худалдан авалтын дийлэнх нь Монгол Улс юм байна. Үүн дотроо дийлэнх нь энэ сайд дарга нар чинь бүгд гараад явчихлаа тиймээ. Туслан гүйцэтгэх ажил, худалдан авалтын дийлэнх нь Монгол Улсын үүн дотроо орон нутгийн ААН дийлэнх нь байна гэж оруулж өгөх саналтай байгаа юм. Тэгэхгүй бол ингээд Монголд бүртгэлтэй татвар төлдөг гэхээр гадаадын хөрөнгө оруулалттай туслан гүйцэтгэх компаниудаа дагуулаад ирдэг байхгүй юу. Монголчуудын хийж чадах ажил.

Р.Сэддорж: 5 номер хариульъя. Ажлын хэсэг тогтвортой суугаарай.

Д.Цолмон: ЗГХЭГ Цолмон. Бадамсүрэн гишүүний асуултад хариульъя.

Нэгдүгээр асуудал. Ерөнхийдөө нөгөө гэрээний хэлэлцээ нь гэрээний төсөлд бол тодорхой хэдэн асуудлаар анхаарч ажиллаарай гэдэг ийм санал хэлж байна гэж ойлгож байна. Тэгэхээр таны хэлсэн саналууд бол ерөнхийдөө бол гэрээнд тусгагдсан. Энэ бол хууль эрх зүйн хувьд ч гэсэндээ хамгаалалттай заалтууд байгаа. Тухайлбал энэ тусгай зөвшөөрлийг шилжүүлэхтэй холбоотой харилцааг анхааралтай байгаарай гэдэг нь бол Цөмийн энергийн тухай хуулиараа угаасаа 24 дүгээр зүйл дээр нь хориглочихсон байгаад байгаа юм. Тэгээд энэ агуулгыг бид нар гэрээндээ авч үлдээд тусгачихсан байгаа. Тэр бүтээгдэхүүнтэй холбоотой зохицуулалт бол 7 дугаар хэсэг зүйл дээр тусгагдсан. Энэ бол давуу эрхийн хувьцаа эзэмшлийн онцгой эрх дээр дагалдаж орж ирсэн нэмэлт зохицуулалт байгаа. Үүнийг бол та худалдан авах эрхтэй байхаар зохицуулаарай гэдэг өөрчлөөрэй гэдэг ийм санал хэлж байна.

Тэгэхээр худалдан авна, худалдан авах эрхтэй 2 бол нэг утгатай өөрөөр хэлбэл үр дагавар нь бол нэг утгаар ойлгогдоно гэж үзээд бид нар ойлгож байгаа. Харин зүгээр бүтээгдэхүүний 10 хувийг бол доод хэмжээг 10-т барихаар таазаар тусгаад ийшийгээ хэдэн хувь ч авч болох ийм санал хэлж байгаа нь эргээд нэлээн хөрөнгө оруулагчтай, нэлээн тохиролцоо хийх өөрөөр хэлбэл тооцоолол дээр өөрчлөлт гарах л ийм асуудал болох байх аа.

Р.Сэддорж: Нэмж хариулах хүмүүс байна уу? Бадамсүрэн гишүүн тодруулж хариулт хангалтгүй гэж үзэж байна.

М.Бадамсүрэн: Яах вэ энэ нөгөө нэг 10 хувиас доошгүйг худалдан авна гэхээр ингээд заавал авах юм шиг орчхоод байгаа юм. Тэгэхээр яах вэ авч болно

авахгүй ч байж болно. Хэрвээ авбал 10 хувийн хувьцаандаа тэрнээсээ багагүйг байвал ямар вэ гэсэн санал дээр.

Хоёрт нь нөгөө орон нутгийн иргэд энэ ажлын байраар хангагдахад дийлэнх байх гэдэг заалтыг оруулах гээд байгаа нь тэнд Улаанбаатар хотоос хүн ростороор 14, 14 хоногоор очиж ажилладаг биш тэнд нь цаашдаа Багануур шиг, Эрдэнэт шиг ийм суурьшлын бүс хотхон байгуулах тэнд нь гэр бүл нь хүүхэд нь гэрээсээ сургууль цэцэрлэгтээ явдаг гэр бүлээрээ амьдардаг энэ зүйлийг цаашдаа төрийн бодлогын хувьд оруулж өгөөч л гэж байгаа юм. Тэрний чинь нэг үндэс чинь энэ дээрээ орж ирж байгаа байхгүй юу. Хууль гэрээн дээрээ юу гэж тусахаас хамаараад дараагийн ажил амьдрал, иргэдийн ард түмний энэ ажил амьдрал чинь энэ төрийн шийдвэрээс хамаарч явах учраас энэ бодлого руугаа явахгүй ингээд хязгаарлаад наана нь ингээд тавьчхаад байхаар чинь цаашаа энэ бодлого чинь явахгүй шүү дээ. Иргэн хүн тэнд энэ гэрээг байгуулж чадахгүй байхгүй юу. Төр байгуулна. Тийм учраас төр ийм.

Р.Сэддорж: 4 номер хариулъя.

Д.Далайжаргал: Гишүүний асуулт хариулъя. Энэ 2 чухал асуудал юм аа. Энэ хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсны дараа 2 гэрээг бид нар шинэчилж оруулж ирэх юм. Тэр нь 2013 онд байгуулсан хувьцаа эзэмшигчдийн гэрээ, 2016 онд байгуулсан орд ажиллах гэрээ 2013 онд байсан хувьцаа эзэмшигчдийн гэрээтэй тэр ТЭЗҮ, ТУЗ-ийн тоог өргөтгөх энэ тэр асуудлыг ярьж болно. Энэ нээлттэй байгаа. 2016 оны орд ажиллах гэрээг шинэчлэхдээ бид нар таны ярьж байгаа тэндээс ажлын байраар хангах орон нутгийн иргэд ажиллана гэдгийг оруулж өгнө өө. Энэ бол 2 гэрээ тусад нь бид нар ахиж байгуулах юм. Ер нь Француудтай ярьж байгаад таны ярьж байгаа үнэн. Эхлээд тендер бүгдийгээ орон нутагтаа зарла, орон нутаг нь энийг үнэхээр хүчрэхгүй дийлэхгүй бол Монгол Улсад Улаанбаатар хот дараагийн шатдаа зарла гэдэг ийм юмыг яриад тохиролцоод явж байгаа.

Р.Сэддорж: Өөр нэмж хариулах хүн байна уу? Үгэн дээрээ хэлж болно.

Энхцэцэг гишүүн асуулт асууя.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу? 2 асуулт байна.

Нэгдүгээрх асуулт болохоор энэ гэрээний 10.1, 10.2 дээр уурхайн хаалттай холбоотой ийм заалтууд байна л даа. Тэгэхээр 1 дүгээр асуулт болохоор энэ хаалт дээр ямар санхүүгийн баталгаа гаргах асуудлыг тусгаж болохгүй байсан уу? Яагаад гэвэл олон улсад яг ийм хаалттай холбоотой санхүүгийн баталгаа тусгадаг тийм туршлага байдаг юм байна. Яагаад гэхээр хаалт гэдэг маань ерөнхийдөө мэдээж яах вэ уурхай маань зарчмынхаа дагуу яваад хаалтаа хийгээд, нөөц нь дуусаад, хаалтаа хийх бол нэг өөр хэрэг. Гэтэл магадгүй явцын дунд энэ компани дампуурах ч гэдэг юм уу, ямар нэгэн байдлаар давагдашгүй хүчин зүйлээс болоод энэ компани маань байхгүй болоод хаалт хийгдэхэд тэр хаалтыг Байгаль орчныг сэргээхтэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн нөөцийг бий болгохын тулд олон улсын банкны баталгаа ч гэдэг юм уу тийм хаалтын баталгааг оруулдаг л юм байна л даа гэрээн дээр.

Тэгэхээр энэ удаа энэ хаалтын хэсгийг харахаар тийм юм ороогүй байна. Тэгэхээр энийг боломж байсан уу?

2 дугаар асуулт болохоор тэр 9.2 дээр байх аа. Байгаль орчны сэргээлттийн юун дээр болохоор 900 мянган ам долларыг барьцаа гээд оруулсан байна л даа. Тэгэхээр энэ том уурхайн хувьд маш бага мөнгө баталгаа тавигдсан байна шүү дээ. Энэ дээр ихэсгэх боломж байхгүй юм уу? Байгаль орчны тэр хэсэг дээр 900 мянган доллар гэдэг маш бага мөнгө харагдаж байна л даа. Тэгэхээр нөгөө Байгаль орчны хуулиараа нэг жилийн нөхөн сэргээлттийнх нь төсвийнх нь 50 хувийг баталгаа тавьдаг гэсэн ийм хуультай л юм байна л даа. Тэгэхээр магадгүй тэр нөгөө нэг жилийнх нь нөхөн сэргээлттийн төлбөр нь хэт бага байгаа юм биш үү. Тэрнээсээ болоод энэ байгаль орчны баталгаа нь 900 мянган амдоллар гээд энэ гэрээнд орж ирж байгаа нь хэн ч харсан маш бага дүн харагдаж байна аа. Энэ дээр нэг тайлбар өгөөч гэж хүсэж байна.

Р.Сэддорж: Хариулт 6 номер.

Г.Намчинсүрэн: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Намчинсүрэн гишүүний асуултад хариулъя аа.

Ер нь бол уурхайн нөхөн сэргээлт хаалтын харилцааг Ашигт малтмалын хуульд заасны дагуу Байгаль орчин аялал жуулчлалын сайд болон хуучин бол Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан журмын хүрээнд зохицуулдаг байгаа. Бид нар бол энэ цөмийн энергийн хууль дээр арай энэ салбар дээр онцлог юм гэдэг үүднээсээ 11 сард Улсын Их Хурлын баталсан хууль дээр нөхөн сэргээлт хаалтын барьцаа хөрөнгө авах энийгээ бол олон улсын хуримтлал үүсгээд явах болон Монгол банкны тусгай дансанд байршуулах эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгсөн. Мөн хаалт нөхөн сэргээлттийн төлөвлөгөөг бол 5 жил тутам боловсруулж ашиглалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө 5 жил тутам боловсруулж тэгээд уурхайн хаалтын үе шатаас өмнө 5 жилийн өмнө дахин тодотгохоор бол хуульчилж өгсөн. Энэ хүрээндээ бол ашиглалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө бол хаалтын төлөвлөгөөгөө бол энэ компани төсөл боловсруулагч маань өөрсдөө боловсруулаад өгөх үүрэгтэй. Мөн уурхайн нөхөн сэргээлт хаалтын барьцаа хөрөнгийг хуримтлал үүсгэх замаар шийдвэрлэхээр бол хөрөнгө оруулагч талтайгаа тохиролцоод явж байгаа.

Р.Сэддорж: 4 номер нэмж хариулъя өөрийгөө танилцуулаад.

Д.Далайжаргал: Далайжаргал Мон-Атом. Тэр 960 сая долларын үнэ тэр маш зөв асуулт. Энэ чинь ингэсэн юм 2021 оны 7 сараас 2022 оны 6 сарыг хүртэл бид нар туршилтын үйлдвэр гэж хийгээд туршилтын үйлдвэр дээр 10 тонн шар нунтгийг гаргаж авахад зориулж барьцаа хөрөнгийг л байлгасан юм. Тэгэхээр одоо үндсэн хөрөнгө оруулалтад энэ мөнгийг бид нар таны ярьж байгаа шиг нэмэгдүүлэх боломжтой. Ер нь хаалтын байгаль орчны нөхөн сэргээлт нийтдээ 330 сая долларыг хуримтлуулж цуглуулах юм байгаа юм шүү дээ.

Р.Сэддорж: Тодруулж асууя Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: Баярлалаа. Тэгэхээр яг тэр хаалтын баталгааг одоо ингээд ямар ч байсан Цөмийн энергийн хууль дээр суучихжээ. Тэгэхээр цөмийн энергийн хуульд суучихлаа гэдэг маань энэ гэрээнд яг юу гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ гэрээндээ оруулж өгч болохгүй юм уу гэдэг асуудал байна.

Хоёрдугаарт болохоор сая тэр ингээд нэгэнт гэрээн дээр ингээд л 900 мянган ам доллар гээд л биччихсэн л бол тэгээд л энэ гэрээ л гэрээ шүү дээ. Тэгэхээр нөгөө таны саяын ярьж байгаа шиг ингэж өөрчилж болно ихэсгэх хэрэгтэй гэдэг асуудал нь жоохон хаягдаад байгаа юм биш үү? Тэгэхээр гэрээн дээр л гол нь сууж өгөх хэрэгтэй юм биш үү? Гэж бодож байна л даа.

Р.Сэддорж: Хариулт байна уу? 5 номер.

Д.Цолмон: ЗГХЭГ Цолмон. Энхцэцэг гишүүний асуулт дээр нэмэлтээр хариулъя аа. Энэ цөмийн энергийн тухай хууль дээр энэ 2 энэ баталгааны сантай холбоотой зохицуулалт байгаа. Таны тодруулаад байгаа тэр 900 мянган амдоллартой холбоотой хэсэг бол сая Далайжаргал захирлын тайлбарласнаар энэ туршилтын үйл ажиллагаанд зориулж байршуулсан мөнгөн хөрөнгө байгаа. Энэ мөнгөн хөрөнгийг яг энэ гэрээ батлагдаад ашиглалтын үйл ажиллагаа эхлэх тохиолдолд Засгийн газраас дахиж энэ мөнгөн хэмжээг бол тогтоож өгч тэр тогтоосны дагуу бол хөрөнгө оруулагч маань тухайн дансандаа байршуулах ийм үүргийг хүлээж байгаа юм. Энэ 900 мянга гэдэг яагаад энэ гэрээн дээр орсон бэ гэвэл ер нь туршилтын хугацаанд энэ Зөөвч овоо ордын туршилтын хугацаанд ийм мөнгөн хөрөнгийг байршуулсан юм шүү гэдгийг зүгээр баталгаажуулж энийг бол дахиж тооцооллын дүнд Засгийн газраар оруулсны дараа энэ мөнгөн хөрөнгө нь шинээр шинэчлэгдээд явах ийм зохицуулалт байгаа юм аа.

Р.Сэддорж: 3 асуулт байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал амьтны эрүүл мэндийн газрын дарга байгаа. Ингээд энэ өнгөрсөн хугацаанд чинь их сонин сонин мэдээллүүд гарсан тиймээ. Энэ үнэхээр үнэн юм уу? Энэ 2, 3 толгойтой хурга ишиг тугал гардаг гэсэн гарсан юм уу. Энэ дээр нэг хариулж өгөөч.

Хоёрдугаарт нь сая Бадамсүрэн гишүүн ярьж байна. Эрдэнэтийн үйлдвэрийг дагалдаад Эрдэнэт хот байгуулагдсан Багануурын уурхайг түшиглэж Багануур хот байгуулагдсан, Оюу Толгой компанийг дагалдуулж компанийн хувьд бол одоогийн байдлаар Оюу Толгой компанийн барьсан орон сууц юмнууд ажилчдын орон сууц, сургууль, цэцэрлэг юмнууд Ханбогд дээр яг Оюу Толгойн ажилчдын гэдэг утгаараа байхгүй. Оюу Толгой компани нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн аймаг орон нутгийн сургууль, цэцэрлэг, юмнуудыг барьж байгаа. Тэгэхээр энэ Дорноговь аймаг дээр төвлөрөх үү? Улаанбадрах сум дээр төл төвлөрөх үү? Энэ маш чухал асуудал.

Тэгээд эхнээсээ ажилчдынхаа орон сууцыг энэ Улаанбадрах сумдаа төвлөрүүлээд ингээд явна биз дээ. Дорноговь аймагт 1 тэрбум доллар үлдэнэ гэж Улсын Их Хурлын гишүүд ойлгосон. Энэ төсөл дуусахад. Энэ төсөл цаашдаа байгальд үзүүлэх хүний амьдралд үзүүлэх нөлөөллийг нь эцсийн байдлаар тооцоогүй гэж бид нар ойлгосон. Тооцох боломжгүй байгаа гэж ойлгосон.

Дараагийн асуулт нь усны төсөл дээр Батбаяр дарга байгаа байх. Энэ говийг усжуулах дээр энэ төслийн нэмэр оролцоо байна уу? Хэрлэн тооно төсөлтэй энэ холбогдох нэмэр болох ийм оролцоо байна уу гэдэг ийм 3 асуулт байна. Хариулт нэг номер уу? 3 номер эхлээд хариулъя.

Н.Тэгшбаяр: Гишүүний асуултад хариулъя. Физикийн ухааны доктор Тэгшбаяр байна. Энэ уранаас болж мал хордсон тухай цуурхал сүүлийн бараг 10 гаруй жил тогтмол болж байгаа ийм ажил. 2013 оноос хойш Засгийн газар мөн Засгийн газар Ерөнхий сайдын захирамжаар Засгийн газрын тогтоолоор ШУА-ийн

Ерөнхийлөгчийн зарлигаар гэх мэт 8 орчим шинжлэх ухааны ажлын хэсэг очиж ажилласан. Тэгээд энэ уранаас болж ямар нэгэн мал хорогдсон тухай ийм асуудал байхгүй гэдгийг тогтоосон.

Тийм учраас бол энийг нэг талдаа гараад шууд ойлгочих шаардлагатай. Энэ талаар бол ажлын хэсэгт орж ажиллаж байсан. Монгол Улсын гавьяат Ганболд гуай.

Р.Сэддорж: Нэг номер үргэлжлүүлэн хариулна, нэмж хариулъя.

Б.Болдбаатар: Гишүүний асуултад хариулъя аа. Мал эмнэлгийн Ерөнхий газар Болдбаатар хамгийн сүүлд 2020 онд ЗГХЭГ-ын даргын тушаалаар батлагдсан бүх холбогдох яамдууд харьяа газруудтай бол хамтарсан ажлын хэсэг энэ дээр бол нэг сар гаран ажилласан байдаг. Тэгээд энд дүнгээр бол хайгуул эхэлснээс хойш бол нийтдээ ургийн гажигтай төл мал гарсан гэсэн мэдээлэл бол нэг 80 мэдээлэл байдаг. Үүнээс зөвхөн хоёрхон нь л мал эмнэлгийн байгууллагад албан ёсоор ирсэн. Бусад нь нотлогдоогүй батлагдаагүй ийм мэдээлэл. Энэ бүс нутагт бол бусад бүс нутагт л гардаг ижил төстэй халдварт өвчнүүд халдваргүй өвчнүүд ийм юмнууд бол ердийн нөхцөлөөрөө гарч байгаа. Гэхдээ энд зарим нэг нөгөө байгалийн илэрц өндөртэй хүнд металлын илэрц өндөртэй ийм хэсгүүд дээр нь бол нөгөө лабораторийн шинжилгээгээр эд эрхтэн дээр зарим хүнд металлууд зөвшөөрөгдөх хэмжээнээс чинь өндөр байна гэсэн ийм үзүүлэлттэй байдаг. Ийм учраас саяын гэрээний нөхцөлд заавал мал, амьтны эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний тайлан гаргуулсны дараа ашиглалт эхэлнэ гэдэг заалтыг 1 дүгээрт оруулсан.

Хоёрдугаарт гэрээний нөхцөл дээр нөлөөллийн үнэлгээний тайлангаар эрсдэлтэй гэж тооцогдсон гарах юм бол тухайн бүс нутгийг нь малыг нь чөлөөлж нөхөн олговрыг хөрөнгө оруулагч тал хариуцна гэсэн ийм заалт, ийм 2 заалтыг бол гэрээний төсөлд оруулсан байгаа.

Р.Сэддорж: Нэмж хариулах хүн байна уу? Тэр өөрийгөө цаашаа аваад явчих чадвартай. энэ саяын мал эмнэлгийн асуулт хариулт энэ протоколд тэмдэглэгдэж байгаа маш чухал. Та бүгдийн хариултууд ингээд түүхэнд үлдэнэ шүү. Энэ дээр ингээд хариуцлагатай хариулж байна гэж ойлголоо. Тэгээд энэ дараагийн асуултад хариулт авъя. Сая Тэгшбаяр доктор хэлсэн. Та 2 бүрэн итгэлтэй хэллээ шүү дээ ийм юм байхгүй гэж хэллээ. Ийм 2, 3 толгойтой энэ ордоос үүсэж хайгуул эд нараас үүссэн юм байхгүй гэж хэлсэн шүү. Ингээд энэ өөрийгөө энэ цаашаа аваад явчих чадвартай энэ хот суурин газар үүсэх юм уу? Энэ дээр хариулт байна уу? Дараа нь Батбаяр дарга усны талаар хариулт хэлээрэй.

Батбаяр дарга 6 номер.

З.Батбаяр: Та бүгдийн өдрийн амгаланг айлтгая аа. Хэрлэн тооно төсөлтэй төдийгүй ерөөсөө манай Монгол Улсын хэмжээнд усны нөөцийн жигд хуваарилалтыг бий болгох гэсэн энэ том зорилгод маань маш их ач холбогдолтой төсөл гэж ойлгож байгаа. Дунд нь задлаад хэлье. Бид бол 1 дүгээрт Монгол Улсын хэмжээний усны нөөцийн жигд хуваарилалт.

Хоёрдугаарт нь 29 сав газар болгож Монгол Улс хуваагдаад тэр дотроо 21 сав газрын захиргаа ажиллаж байгаа. Энэ сав газар дотроо бас жигд хуваарилалтыг бий болгох нь энгийн үгээр говийн бүсийн усан хангамж гэдэг үгээр илэрч байгаа бол одоо энэ ураны төсөл хэрэгжих талбай маань Галав бүс Долоодын говь буюу

Монгол Улсын говийн бүсийн зүүн хэсгийг усаар хангахад нэлээн чухал үүрэг гүйцэтгэнэ. Энийг тодруулаад хэлэх юм бол 3 янзын юм хэлж болж байгаа.

Нэгдүгээрт нь 33 литр секундйн усны газрын доорх орд газар дээр энд олборлолт хийгдэнэ. Эндээс усны ашиглалт нь 17 литр секундтэй байна. Дээр нь гэрээн дээр та бүхэн харж байгаа 8.4 дээр нэлээн тодорхой заачихсан байж байгаа. Усны балансыг маш нарийн тооцож эхлэх нь яг тэр бүс нутаг дээр юуны Хэрлэн тонн төслөөс ус аваачих шаардлага байгаа юу үгүй юу гэдгийг тодорхойлоход маш чухал болно. Дээр нь нийт ганцхан Галав бүс, Долоодын говь гэхгүйгээр Монгол Улсын говийн бүс буюу 4 аймгийн нутаг дэвсгэрээр тооцоод аваад үзэх юм бол 7 мянга орчим литр секундйн ус шаардлагатай байгаа. Тэндээс одоогийн байдлаар 3500 орчмыг бид нар хангаж чадна гэвэл дахиад 3500 литр секундйн ус очих учраас Хэрлэн тооноос 1200-аас 2 мянган литр секундйн ус очно гэж тооцоод Орхон Онгиос 500 орчим литр секундйн ус очно гэж тооцоод үлдсэн усыг газрын доорх усны эрэл хайгуул болоод бусад эх үүсвэрээс шийднэ гэж байгаа учраас маш чухал шийдэл болно. Ер нь яг энүүнтэй адилхнаар төсөл болгон дээр усны хэрэглээг нь маш нарийн тооцоод энийгээ улс орны хэмжээнд болоод сав газрын хэмжээнд нь давхар тооцож явна. Дээр нь нэг чухал юм нь ач холбогдол нь бас жишиг болохуйц юм нь газрын доорх усны мониторингийн сүлжээ байгуулаад энэ мониторингийн сүлжээ нь газрын доорх усны түвшний хэлбэлзлээс гадна чанарын хяналтыг давхар хийж явах учраас нийт Монгол Улсын усны газрын доорх мониторингийн сүлжээнд холбогдсоноороо нэгдсэн байдлаар хяналт тавих боломж гарах юм гэсэн ийм хариултыг эхний ээлжид өгч болохоор байна аа. Баярлалаа.

Р.Сэддорж: Өөр нэмж хариулах хүн байна уу? Цолмон дарга хариулах уу? Тэр ажилчдын хот тосгон тэр юман дээрээ төлөвлөсөн юм байхгүй байгаа юм байна тиймээ. 4 номер.

Д.Далайжаргал: Гишүүний асуултад хариулъя. Ер нь Зүүнбаян сум дээр төвлөрч хот тосгон бий болно. Эхний ээлжид 500 хүний ажилчдын байр хийнэ. Ер нь дэд бүтэц өөрөө 3 салбарын дэд бүтцийг хийх юм. Төмөр зам, авто зам, цахилгаан гэсэн юм байгаа. Сайншанд хот аймгийн төв, Сайншандаас Улаанбаатар хүртэл 100 км тогны өндөр хүчдэлийн шугам татна. 160 км авто замыг барина. Тэрэн дотроос 60 км нь засмал зам байна. Энэ нөгөө гол бараа бүтээгдэхүүнээ зөөх зам байна.

Хоёрдугаарт нь зам Зүүнбаян дээр төмөр замыг өргөтгөнө гээд ийм 3 дэд бүтцийг тойрч тодорхой хэмжээний хот суурин бий болно.

Р.Сэддорж: Улаанбадрахчуудад бол таалагдахгүй л юм байна. Өөрийнх нь суманд байгаа ордоос өөрийнх нь суман дээр юу ч барихгүй Зүүнбаян гэж сумыг хөгжүүлэх гээд байна шүү дээ. Тэгэхээр наад юу чинь бол нутгийн иргэдэд бол таалагдахгүй. Ийм учраас та нар энийгээ эргэж хар. Зүүнбаян дээрээ ч явна, Улаанбадрах дээрээ ч явна. Энийгээ холбох юмнуудаа яах хэрэгтэй. Тэгээд санал дээрээ хэлье. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн үг хэлье.

П.Сайнзориг: Баярлалаа. Хөрөнгө оруулалтын гэрээг зарчмын хувьд ингээд дэмжиж байгаа юм. Гишүүд маань тодруулах зүйлээ асууж байх шиг байна. Энэ

талаар бол нэлээдгүй мэдээллүүдийг яах вэ зүгээр шийдвэр гаргах түвшинд өгөгдсөн. Ер нь зүгээр томоохон төслүүдийг олон нийтэд тэр мэдээллээ сайн өгөөрэй гэдэг тэр зарчмыг хэдүүлээ яг энэ дээрээс нэг жишиг болгоод явах нь зүйтэй. Би бас түрүүн хэлж байгаа гишүүдийн байр суурийг дэмжиж байгаа юм. Өмнө нь ч бас Цөмийн энергийн тухай хууль орж ирэхэд хүртэл яг л энэ зарчмыг хэлж байсан. Бидний нэг тийм алдаа бол тэр байгаад байгаа юм. Ерөнхийдөө бас яах вэ энэ төслийн ач холбогдлыг зөв ойлгуулж бас иргэд олон нийтэд өгөөгүйгээс яг энэ дээрээс нь илүү хар мэдээ гэдэг юм уу мушгин гуйвуулж байгаа мэдээ түгээлт нь илүү явчхаж байгаа юм.

Тэгээд энэ дээрээс ерөөсөө иргэд маань итгэдэггүй. Мэдээж энэ хөрөнгө оруулалтыг дагаад технологи орж ирж байгаа. Энэ дээр эерэг сөрөг үзэгдлүүд байгаа боловч тэр сөрөг үзэгдлийг даван туулах бууруулахад ийм арга хэмжээнүүдийг яг мэргэжлийн түвшинд нь авч байгаа юм, авах юм гэдэг зүйлийг хүртэл ойлгуулмаар байгаа юм. Тэгэхгүйгээсээ болоод л ерөөсөө яг сая хурлын дарга ч асууж байх шиг байна. 2, 3 толгойтой хонь хурга, ботго, ишиг ярьдаг. Эргээд л ерөөсөө Монгол Улсыг тэр чигт нь л гамшигт оруулах гэж байгаа юм шиг ярьж байгаа байхгүй юу. Тэгээд яг ийм төслүүдийг зөв мэдээлэл өгөх нь зүйтэй байгаа юм аа. Тэгээд ер нь зүгээр өмнөд хөрш ч, тэр хойд хөрш ч тэр яг энэ цөмийн түлшийг хадгалах агуулах бол манай хил залгаа нөхцөл байдалдаа хүртэл байж л байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр мэдээж тодорхой технологийн горимуудыг сахиулдаг учраас л аюулгүй байж байгаа байх. Тэгээд энэ бол зөвхөн түлш хийх гэж байгаа зүйл биш. Одоом шар нунтгийг экспортод гаргах гэж байгаа гэдэг зүйлийг 1 дүгээрт бид нар өгмөөр байгаа юм. Тэгээд асуудал холилдож зөв мэдээлэл өгөөгүйгээс болоод нэг л дараа дараагийн нөгөө бүүр нөгөө баяжуулалтын түвшний айдсыг бид нар эндээ яриад ингээд энэ томоохон төслүүдийн бас нэг саад бэрхшээл болох юм аа. Тэгээд ерөнхийдөө энэ зарчмыг хэлж байгаа юм.

Хоёрдугаарт яах вэ би зүгээр манай ер нь Эдийн засгийн байнгын хороо бас анхаармаар байна. Энэ Улсын Их Хуралд орж ирж байгаа би ч энийг анхааръя л гэж бодож байна. Ер нь зүгээр орж ирж байгаа нийтийн эрх зүйн болон хувийн эрх зүйн олон улсын гэрээнүүдийг бид ялгамжтай авч үзэхгүй бол ерөөсөө л нэг Байнгын хороотой зөвшилцөнө гэдэг нэг тийм ерөнхий тойм зургууд байна аа. Мэдээж олон улсын гэрээнүүдийг бид зөвшилцөөд явах нь зүйтэй. Тэгэхдээ энэ хувийн эрх зүйн гэрээнүүдийг бол илүү жоохон арай өөр зүйгээр мэргэжлийн Байнгын хорооны илүү их дэлбрэйшн хийж авч явах хэлэлцэж мэргэжлийн байдлаасаа хандах нь зөв болов уу гэж бодоод байгаа юм. Тэгээд бид санал дүгнэлтээ Аюулгүй байдлын байнгын хороонд хүргүүлэх байх.

Тэгэхээр ер нь энийг цаашдаа анхаармаар байна аа. Тэгээд энэ зөвшилцөх гэдэг үг нэр томъёог нь ч гэсэн ер нь сайжруулах ёстой юм байна шүү гэдэг зүйлийг би энэ протоколд зүгээр үлдээж байгаа юм. Гэрээтэй холбоотой янз бүрийн юм байхгүй. Ер нь зүгээр цаашдаа энэ олон улсын хууль эрх зүйн гэрээн дээр аль Байнгын хороогоор орох уу, үгүй юу гэдэг зүйлийг их оновчтой болгох ёстой юм байна.

Дээрээс нь энэ процессыг бас нэг ойлгомжтой зөвшилцөх гэдгийн цаана ямар агуулга байх вэ гэдгийг маш ойлгомжтой хөрөнгө оруулагч талдаа хэлмээр байна. Энэ хөрөнгө оруулалт талдаа хууль эрх зүйн тогтвортой байдлыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон ҮХЦ-ийн шийдвэрээс орж байгаа өөрчлөлтөөс бусад байдлаар энэ тогтвортой байдлыг илүү их хангах хөрөнгө оруулагчдын итгэлийг

татах энэ асуудал дээр бид ер нь цаашдаа манай Байнгын хороо ажиллах ёстой юм байна гэдэг зүйлийг зүгээр би зарчмын хувьд энэ томоохон төслийг хэлэлцэж байгаа дээр протоколд үлдээж байгаа юм аа. Баярлалаа.

Р.Сэддорж: Зөвшилцөнө гэдгийг бол Засгийн газарт цаашаа хэлцэл хийхийг зөвшөөрч байна л гэж хууль дээр ойлгож байгаа. Ингээд Уянгахишиг гишүүн үг хэлнэ.

Г.Уянгахишиг: Бүгдээрэнд нь өдрийн мэнд хүргэе ээ. Тэгэхээр энэ дээр ер нь бол яг энэ гэрээнийхээ төсөлтэй бол бид хэд танилцаад явж байгаа. Тэгэхээр гэрээний төсөл энэ гэрээ маань ингээд хөрөнгө оруулалтын гэрээ зурагдсанаар бүх юм болчихлоо гэсэн үг бол бас биш. Тиймээ хөрөнгө оруулалтын гэрээний 19 дүгээр зүйлд заасны дагуу энэ гэрээ маань 12 сарын хугацаанд хувьцаа эзэмшигчдийн гэрээгээ, орд ашиглах гэрээгээ, компанийн дүрмээ өөрчлөх энэ бүх ажиллагаануудыг хийх ёстой. Мөн энэ хугацаанд ТЭЗҮ-ээ дахиж өөрчлөх ёстой. Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээгээ сайжруулах өөрчлөлтөө оруулах ёстой гэх мэтчилэн яг энэ төрөөс хамаарсан ажиллагаанууд хийгдэж байж энэ гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ ээ.

Тийм учраас багийнхандаа юу гэж хэлмээр байна вэ гэхээр Засгийн газарт ч гэсэн тийм юу гэж хэлмээр байна вэ гэхээр бид нар өнөөдөр хөрөнгө оруулалтын гэрээн дээр гол тохирсон нөхцөлүүд байгаа. Мөн ТУЗ-тэй холбоотой шийдвэр гаргалтад нөлөөлөх тийм хөрөнгө оруулалттай холбоотой энэ бүх нарийн зохицуулалтуудаа хувьцаа эзэмшигчдийн гэрээндээ болон компанийн дүрэмдээ маш нарийн тусгаж өгөөрэй илүү дэлгэрүүлж тусгаж өгөөрэй. Тэгэхээр энэ дээрээ анхаараасай гэж бодож байна, хүсэж байна. Нөгөө талаасаа одоо бид нарын яриад байгаа энэ маш олон зүйлүүд бол орд ашиглах гэрээн дээр өөрчлөлт болж тусаж орж ирэх ёстой. Тэгэхээр энэ 12 сарын хугацаанд яах вэ хамгийн ихдээ 12 сарын хугацаанд энэ бүх ажлыг хийж гүйцэтгэх ёстой. Мэдээж болж өгвөл энэнээсээ богино хугацаандаа хийгээд энэ төсөл маань энэ гэрээ маань хүчин төгөлдөр үйлчлээд явчихвал мэдээж илүү давуу байдал үүснэ.

Тэгэхээр энэ хооронд яг тухайн гэрээ хэлцлүүд дээр тусгах юмнуудаа илүү нарийвчилж сайн тусгаад энэ дээрээ ч гэсэн тодорхой хэмжээнд Байнгын хороодтой зөвшилцөх хэрэгтэй зүйлс байх тийм энэ болгон дээрээ ажиллаад яваасай гэдэг ийм саналыг хэлмээр байна. Нэг зүгээр маш детальный нэг санал байгаа нь болохоороо гэрийн 3.1 дээр хөрөнгө оруулалтын тухай асуудлууд байгаа юм. Тэгэхээр гэрээний 3.1.1 дээр анхны хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалт гэдэг 2 ойлголт яваад байгаа. Энэний анхны хөрөнгө оруулалтыг бол зөвхөн өөрийн хөрөнгөөр хийнэ гэдэг заалт нь байж байна. Нөгөө хөрөнгө оруулалтын буцаад үлдсэн хэсгээ өөрийн хөрөнгөөр хийх үү эсвэл зээл авч болох юм уу гээд дэг энэ асуудал нээлттэй үлдээд байна аа.

Тэгэхээр энэ дээр уг нь бол санаа нь хөрөнгө оруулалт гэдэг маань буцаагаад яг хувь нийлүүлсэн хөрөнгө рүү хөрөнгө оруулагчийн оруулах тэр хөрөнгө оруулалтын хэмжээг инвестмент гэдгээр тодорхойлоод явчихсан байгаа учраас энэ ч гэсэн өөрөө зээлээр хийгдэхгүй байх ёстой шүү гэдэг энэ саналыг ер нь протоколд оруулаад хэлчихмээр байна. Тэгэхгүй бол 500 дээр нэмэх нь үлдэх хэсгийг гуравдагч этгээдийн зээлээр ч гэдэг юм уу явчихна гэвэл энэ маань нэг арай өөр ойлголт болоод явчих болов уу. Энэ нөгөө талаасаа орчуулгатай холбоотойгоор нэг засвар ямар ч байсан оруулах хэрэгтэй байгаад байгаа нь энэ 3.1.е дээр байгаа.

Энэ дээр болохоор анхны хөрөнгө оруулалтын хувьд нөгөө зөвхөн өөрийн хөрөнгөөр хийнэ гэдэг зохицуулалт байгаа юм. Гэтэл нөгөө Англи дээр бол яг тэгээд явчихсан байж байдаг. Гэтэл буцаагаад Монгол дээрээ болохоор зөвхөн анхны хөрөнгө оруулалтыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ гээд нэг найруулгын шинжтэй алдаа гарчихсан яваад байгаа. Энийг нэг анхаараад засчхаарай. Ер нь энэ зөвхөн гэдгийн дараах анхны хөрөнгө оруулалтыг гэдэг үг шаардлагагүй яваад байгаа. Өөрөөр хэлэх юм бол дээрх 3.1.д дүгээр зүйлд тусгасан анхны хөрөнгө оруулалтын хувьд ингэхгүй ингэхгүй бөгөөд өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ гээд ингээд үргэлжлээд явахад бол ойлголт нь өөрөө яг Англитайгаа нийцэж явж байгаа учраас миний анзаарсан орчуулгын засвар гэх юм уу нэг ийм засвар байгаад байна. Тэгэхээр бусад орчуулгынхаа юунуудаа ч гэсэн нэг дахиад нягтлаад үзчихээсэй гэдэг ийм саналтай байна.

Р.Сэддорж: Соронзонболд гишүүн үг хэлнэ.

Л.Соронзонболд: Энэ гэрээний борлуулалтын үнэ болон борлуулалтын үнэлгээ 2-ын зөрүүтэй холбоотой асуудал дээр ер нь цаашдаа ийм үл ойлголцол үүсэж болзошгүй юм аа. Тийм учраас энэ хувилбарыг бас тооцоололтой бодож үзэх ёстой байх гэж зөвлөмөөр байгаа юм. Яагаад гэхээр борлуулалтын үнэ болохоор борлуулалт хийхээс өмнөх 2 биржийн дундаж байгаад байгаа. Борлуулалтын үнэлгээ болохоор бол олон улсын зах зээлийн тухайн сарын дундаж байгаад байгаа.

Тэгэхээр энэ 2 ингээд нэг нь 42 хоног нөгөөдөх нь 30 хоног гэж ойлгож болохоор. Ийм 2 ялгаатай хугацааны энэ дунджийг тооцоолж байгаа гэдгээрээ ийм ялгаатай асуудал гарч болзошгүй. Тэгээд тэр нь болохоор бид нарын тооцоод байгаа өгөөжид ямар хэмжээгээр нөлөөлж болзошгүй вэ гэдэг дээр ер нь тооцоолол хийж үзэх ёстой болов уу л гэж зөвлөмөөр байна аа.

Р.Сэддорж: Энхцэцэг гишүүн үг хэлнэ.

М.Энхцэцэг: Би түрүүний асуусан 2 асуулттай холбоотой саналаа хэлье гэж бодож байна. 1 дүгээр асуудал болохоор тэр хаалтын барьцааны асуудлыг энэ гэрээнд тусгаж өгөх нь зүйтэй юм болов уу гэсэн саналтай байна.

Хоёрдугаар асуудал болохоор тэр байгаль орчны нөхөн сэргээхтэй холбоотой 900 мянган доллар хэт бага байна тэгээд ерөнхийдөө туршилтын үеийн тэр нөхөн сэргээхтийн зардлаас энэ гэрээнд тусгахаасаа илүүтэй үйл ажиллагаа нь жигдэрсэн үеийн нэг жилийн нөхөн сэргээхтийн зардлыг энэ гэрээн дээрээ тусгасан нь зүйтэй юм болов уу гэсэн ийм саналтай байна аа.

Р.Сэддорж: Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Лиценз болон компанийн хувьцааг бусдад шилжүүлэх асуудлыг аль болох хаах чиглэлээр гэрээний төсөл дээр нэмэлт, өөрчлөлт оруулж өгөөч гэсэн санал байна. Тэгээд энэний учир холбогдлыг маш сайн ойлгож байгаа байх гэж бодож байна. Жишээ ярих шаардлагагүй байх гэж бодож байна.

Хоёрдугаарт нь тэр бүтээгдэхүүний 10-аас доошгүй хувийг тэр тухайн компанитай ижил нөхцөл нөхцөлтэйгөөр худалдаж авах эрхтэй байх гэдэг ингэж өөрчлөн найруулаач гэсэн саналыг өгч байна.

Гуравдугаарт нь Монгол ажилтны буюу энэ төслийн явцад уурхай ашиглалтын үед ажиллах нийт Монгол ажилчдын дийлэнх нь буюу 51-ээс дээш хувь нь тухайн сөрөг нөлөөлөлд өртөж байгаа бүс нутаг буюу Дорноговь аймаг холбогдох сумдын иргэн байх гэдэг ийм шаардлагыг оруулж өгөх хэрэгтэй 5 хувь маш бага байна. 100 хүний 5 хүн л гэсэн үг шүү дээ.

Дараагийнх нь бол тэр туслан гүйцэтгэх ажил, бараа бүтээгдэхүүний тэр худалдан авах ханган нийлүүлэх ажил гэдэг хамгийн чухал ажил байдаг. Тэгээд энэ ажлын дийлэнх нь орон нутгийн ААН байх гэж оруулах ёстой. Яагаад гэвэл энэ төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд нийслэл хотын түгжрэл, утаа гээд энэ олон асуудлаас орон нутаг руу аль болох бүсчилсэн хөгжлийг дэмжих хүрээнд ААН-ийг гаргая гэж байгаа бодлогоо яг энэ том хөрөнгө оруулалтын парламенттай зөвшилцөж байгаа энэ гэрээн дээр оруулж өгөхгүй бол өөр юун дээр оруулж өгч энэ бүс орон нутгийн хөгжлийг дэмжих вэ гэдгийг энэ ажлын хэсэг дор бүрнээ маш сайн бодох хэрэгтэй. Эндээс төрийн бодлого өнөөдөр бид нарын саналаа өгч байгаа энэ шийдвэр ямар гарахаас тэр тухайн аймгийн сумд амьдарч байгаа малчин иргэний тэр сумын төвийн багшийн, тэр цэцэрлэгийн багшийн, сумын сувилагчийн хувь заяа хамаарна аа.

Тийм учраас ингэж хийж өгөхгүй бол яг үнэндээ бодит байдал дээр та нар яг энэ заалтаар явах юм бол Улаанбаатар хотоос аль нэг дарга даамлын томилгоотой баахан компани очиж наад туслан гүйцэтгэх ажлыг чинь бүгдийг нь хийнэ. Ийм гашуун туршлага байгаа. Би жишээ яривал даанч цаг бага байна. Түүнээс энийг бол яривал зөндөө ярих жишээ байна.

Тийм учраас энэ зүйлийг би бол орон нутагт ажиллаж амьдарч байсан учраас энэ бэрхшээлийг өөрөө яс махаараа мэдэрсэн учраас энэ зүйлийг хэлээд байгаа юм аа. Эндээс гарч байгаа энэ саарал ордноос гарч байгаа шийдвэр болгон чинь тэр орон нутгийн иргэдэд нөлөөлөөд байдаг юм байна лээ. Энийг энэ танхимд орж ирснээр бүүр илүү гүнзгий мэдэрч байгаа хүний хувьд энийг хэлээд байгаа юм.

Тэрнээс энэ дээр хэн нэг хүнийг шүүмжлээд буруутгаад байна гэдэг утгаар битгий хүлээж аваасай. Орон нутгийн яг амьдрал ийм байгаа шүү. Энэ орон нутгийн жижиг ААН-үүдийн бичил ААН-үүдийн өрхийн бизнесийг хамгаалах бодлогыг энд хийхгүй бол яг л ийм байдал үүснэ. Одоо Монголд байгаа энэ бүтээгдэхүүн ухах гэрээтэй газрын тосны компаниудад туслан гүйцэтгэгч компани гээд маш олон компанийг өөрийн орноосоо дагуулаад ирдэг. Энэ нууц биш байгаа. Монгол хүний хийж чадах ажлын байрыг гадаадын туслан гүйцэтгэгч нэртэй компаниуд булааж авч хийж байгаа учраас орон нутагт чинь ажлын байр нэмэгдэхгүй байгаа. Ийм учраас орон нутагт чинь эдийн засаг нь өсөхгүй байгаа. Ийм учраас орон нутгийн иргэд чинь орон нутгийн ААН-үүд чинь бухимдалтай байгаа юм аа.

Тийм учраас энэ гэрээ бол маш чухал аа. Хэрвээ энэ гэрээг тусгахгүй бол би энэ асуудлаар албан бичиг цаашлаад энэ чухал заалтуудыг оруулахын төлөө би тодорхой өөрийн Их Хурлын гишүүнийхээ хувьд тодорхой арга хэмжээг авч ажиллана гэдгээ энэ дээр хэлье.

Р.Сэддорж: Протоколд тэмдэглэж байгаа. Ажлын хэсгийнхэн тэмдэглэж байгаа. Энэ гишүүдийн гарч байгаа саналуудыг нарийн тэмдэглэж ажил хэрэг

болгоорой. Шаардлагатай бол Байнгын хорооноос явуулж болно. Тэгээд түрүүнд хэлсэн саналуудаа энд санал болгоод хэлчихье.

Дорноговь аймгийн Улаанбадрах суманд хэрэгжих төсөл Улаанбадрах сумын төвийг анхаарахгүй бол энэ төсөл чинь цаашаа ард иргэдийн дэмжлэг авахад хэцүү шүү. Тэгээд энийгээ сайн анхаараарай. Тэгээд энэ уурхай дуусахад юу үлдэх юм бэ энийгээ тодорхой болгоорой. Ажилчдын одоо Эрдэнэтийн уурхай ажиллаж байгаа энэ үед Эрдэнэт хот үүссэн. Эрдэнэт хивсний үйлдвэрээс авхуулаад ингээд томоохон бүтээн байгуулалт ажлын байрууд үлдэж байгаа. Энэ Сайншанд дээр үлдэх Улаанбадрах дээр үлдэх, мөн Зүүнбаян дээр үлдэх асуудлуудыг онцгой анхаарч энэ гэрээндээ тусгаарай.

Ингээд Дорнын говийн хөгжлийг дэмжих сан гэж мэдээж нэг иймэрхүү нэртэй байгуулагдах байх. Тэгээд энэ орон нутагт өгч байгаа энэ төлбөр юмнууд чинь энэ сангаараа дамжуулаад тэгээд худалдан авах ажиллагаа нь зарлагдаад ингээд бүтээн байгуулалтууд хийх байх. Дорноговь аймагт бол шаардлагатай зүйл онгоцны буудал байгаа. Зам байна. Улаанбадрах сумыг зайлшгүй Зүүнбаянгаар дамжиж Сайншандтай холбох хэрэгтэй, Эрдэнэ сумтай холбох хэрэгтэй. Мэдээж танай ачаа бараа юмнууд чинь бол Замын-Үүдээр орж ирнэ. Эрдэнэ сумтай холбох шаардлагатай байгаа. Тэгээд байгаль орчны талаас энэ мал эмнэлгийнхэн маань урьдчилан сэргийлээд нэг бүс тогтоогоорой. Янз бүрийн юм гарч мэдэх вий. Энэ тэдэн километрээс том хашаа бариад тэдэн километрээс нааш нүүдэл суудал хийж болохгүй ч гэдэг юм уу гүн өрмийн худаг гаргаж болохгүй ч гэдэг юм уу ийм юмнуудаа эртхэн бас тодорхой болгоорой.

Ингээд юм эхнээсээ тодорхой байсан нь дээр. Дорноговь аймгаас бүтээгдэхүүнээ авдаг хүнсний бараа бүтээгдэхүүнээ авдаг, мал махаа авдаг, аягүй хэлсэндээ байдаггүй шүү дээ. Энэ Уул уурхайн компаниуд чинь. Яг ингээд л гэрээ хийгдэх үед тэгнэ ингэнэ гэххээд л тэгээд л хэрэгжүүлдэггүй. Тэр говийн ард түмнийг тоодоггүй, говийн үйлдвэр юмнуудыг ямар нэгэн стандарт юмнууд дээр ингээд л одоо шаардлагад нийцэхгүй байна гэсэн хариу өгөөд л тэгээд л амыг нь хаачихдаг. Тэгээд ийм сэтгэлгүй уурхай битгий байгаасай л гэж хүсэж байна аа.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна.

Зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор. Ирц гайгүй байна уу? Энэ саналууд мэдээж гэрээн дээрээ тусгана шүү дээ. Гэрээг чинь Засгийн газар хийнэ.

Санал хураалт.

Томъёолол Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

78.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энхтүвшин гишүүний төхөөрөмж ажиллахгүй байгаа учраас дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан танилцуулна аа.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

Ингээд өнөөдрийн Эдийн засгийн байнгын хорооны хурал хэлэлцэх асуудлаа дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

13.03 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА